

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2022 оны \_\_ сарын \_\_ өдөр

Дугаар \_\_

Улаанбаатар хот

“Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- 1.“Компанийн засаглалын кодекс”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
- 2.Кодекс шинэчлэн баталсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн “Компанийн засаглалын кодексийг шинэчлэн батлах тухай” 162 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
- 3.Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үнэт цаас гаргагч, даатгагч, итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэгч этгээдэд энэхүү кодексийг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.
- 4.Нийт компаниудад энэхүү кодексийг мөрдлөг болгон ажиллахыг зөвлөсүгэй.
- 5.Шинэчлэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС

- КОДЕКСИЙН БҮТЭЦ

Энэхүү баримт нь компанийн засаглалын кодексийг батлан хэрэгжүүлэх зорилго, ач холбогдол, хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга, онцолсон оршил хэсэг, компанийн засаглалын үндсэн 9 зарчим, тэдгээрийг нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээний талаарх 37 зөвлөмж болон уг зөвлөмжүүдийг гаргах болсон үндэслэл, ач холбогдлын тайлбарыг агуулсан үндсэн хэсэг болон кодексст ашигласан зарим нэр томъёоны тайлбараас бүрдсэн төгсгөлийн хэсэг гэсэн бүтэцтэй.

- ОРШИЛ

**Зорилго, ач холбогдол:** Компанийн засаглалын кодекс (цаашид “кодекс” гэх)-ийн зорилго нь компанид засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Компанийн засаглал нь компанийн үйл ажиллагааг чиглүүлэх, хянах тогтолцоо бөгөөд байгууллагын зорилго, зорилтыг тодорхойлох, гүйцэтгэлийн хяналтын арга замыг тогтоох, хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо юм. Мөн энэ ойлголтод хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцаа багтана.

Компанийн засаглалын хэрэгжилтийг хариуцах гол субъект нь төлөөлөн удирдах зөвлөл. Хувьцаа эзэмшигч нь төлөөлөн удирдах зөвлөл болон хөндлөнгийн аудитаар дамжуулан компанид зохистой засаглалын бүтэц, зохион байгуулалт бүрэлдсэн эсэхэд хяналт тавина. Компанийн засаглалын сайн туршлагыг хэрэгжүүлснээр тухайн бизнесийн үнэлгээ өсөх, өртөг багатай санхүүжилтийн эх үүсвэр татах, урт хугацаанд тогтвортой хөгжихөд ач холбогдолтой.

**Кодексийн хамрах хүрээ:** Энэхүү кодекс заасан компанийн засаглалын зарчмуудыг Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн бүх хуулийн этгээд дагаж мөрдөнө. Үнэт цаасаа нийтэд арилжаалдаггүй хаалттай компанийн хувьд кодекс заасан зарчмуудыг нэвтрүүлж хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

**Кодексийг хэрэгжүүлэх арга:** Компани энэхүү кодексийн засаглалын зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзэх ба компанийн үйл ажиллагааны онцлог, бүтэц, хэмжээ, хөгжлийн үе шат зэргээс шалтгаалан зарим нэг зөвлөмжийг тухайлан хэрэгжүүлэх бололцоогүй, эсвэл зохион байгуулалтын илүү зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.

Кодексийн хэрэгжилтийг олон улсад түгээмэл тогтсон “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмаар хангуулна. Өөрөөр хэлбэл, компани засаглалын зарчмуудын хэрэгжилтийг тайлагнахдаа кодекс дурдсан зөвлөмжүүдийг биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсныг энэхүү кодексийн хавсралт 1-ийн маягтын дагуу нарийвчлан тайлбарлах үүрэгтэй. Жич: Хэрэгжилт болон тайлбарыг зөвлөмж тус бүрээр гаргана.

Компани кодекст заасан засаглалын зарчмуудын хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа тайлагнах бөгөөд засаглалын тайланг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон компанийн цахим хуудсанд байршуулна. Жилийн үйл ажиллагааны тайланд байршуулахдаа “компанийн засаглалын зарчмуудын хэрэгжилт” гэсэн тодорхой, ойлгомжтой нэршилтэй бие даасан бүлэг болгох, цахим хуудсанд байршуулахдаа шууд харагдахуйц “бидний тухай”, “хөрөнгө оруулагчдад” гэсэн ангилалд уг холбоосыг байршуулна.

Компанийн засаглалыг сайжруулж, бэхжүүлэх нь тогтмол үргэлжлэх үйл явц тул жилд нэг удаа тайлагнаад орхих бус, төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн засаглалаа хэрхэн сайжруулах талаар хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, оролцогч талуудтай байнга зөвлөлдөж, мэдээлэл солилцон шаардлагатай арга хэмжээг тухай бүр авна.

Төлөөлөн удирдах зөвлөл энэхүү кодексийн хавсралт 2 болох “Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр”-ийн үлгэрчилсэн загварыг ашиглан дотооддоо мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журмыг өөрийн онцлогт нийцүүлэн баталгаажуулж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

- **КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМУУД, ЗӨВЛӨМЖ, ТАЙЛБАР**

- ***Компанийн засаглалын үндсэн 9 зарчим:***

- **Хувьцаа эзэмшигчийн эрх**

- *“Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, шаардлагатай мэдээлэл болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана.”*

- **Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн бүтэц, үйл ажиллагаа**

- *“ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг тэнцвэртэйгээр агуулсан, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.”*

- **ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг**

- *“ТУЗ нь үйл ажиллагаагаа тодорхой чиг үүрэг хариуцсан хороодоороо дамжуулан явуулж, эцсийн хариуцлагыг өөрөө хүлээнэ.”*

- **Тайлагнал, мэдээллийн ил тод байдал**

- *“ТУЗ нь компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн зөв, бүрэн бүтэн, тэнцвэртэй байдлыг хангах арга хэмжээг авч ажиллана.”*

- **Аудит, хяналтын тогтолцоо**

- *“ТУЗ нь компанийн аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнт байдлыг хангана.”*

- **Эрсдэлийн удирдлага**

- *“Компани эрсдэлийн удирдлагын тогтолцоог зүй зохистой, хараат бус байдлаар зохион байгуулж, уг тогтолцооны үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.”*

- **Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал**

- *“ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.”*

- **Оролцогч талуудын эрх ашиг**

ТӨСӨЛ 2022.02.21

*“Компани нь үйл ажиллагаа явуулахдаа бусад оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэнэ.”*

- **Байгууллагын соёл**

*“ТУЗ-ийн гишүүд компанидаа бизнесийн ёс зүй, хариуцлагын өндөр хэм хэмжээг тогтоож, өөрөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтанд мөрдлөг болгон хэвшүүлнэ.”*

- **ЗАРЧИМ 1. Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, шаардлагатай мэдээлэл болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана.**

***Зөвлөмж 1.1. Хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан компанийн үйл ажиллагаа, санхүү, засаглалын зохион байгуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан хүргэнэ.***

***Тайлбар 1.*** Компанийн үйл ажиллагааны үндсэн мэдээллийг хөрөнгө оруулагч хэдийд ч танилцаж болох хэлбэрээр, тухайлбал, компанийн цахим хуудсанд байршуулна. Мөн байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлаар бусад оролцогч этгээдтэй харилцах, тэдгээрт тайлагнах ажлыг тогтмол хэрэгжүүлнэ;

***Тайлбар 2.*** Компанийн цахим хуудсанд дараах мэдээллийг байршуулна. Үүнд: Холбоо барих, харилцах этгээдийн талаарх мэдээлэл, ТУЗ-ийн дарга, гишүүд болон гүйцэтгэх удирдлагын товч намтар, компанийн дүрэм, сүүлийн тав хүртэлх жилийн санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайлан, үнэт цаасны арилжаа эрхлэгч болон зохицуулагч байгууллагад хүргүүлсэн, тэдгээрээс хүлээн авсан чухал шийдвэр, мэдэгдэл, ХЭХ-ын зар, шийдвэр;

***Тайлбар 3.*** Компанийн цахим хуудсанд компанийн түүх, бүтэц, бизнесийн үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл, ХЭХ хуралдуулах, ногдол ашиг тараах зэрэг томоохон үйл явдлын хуанли, гаргасан үнэт цаасны төрөл, холбогдох эрх, тэдгээрийн арилжааны үнэ ханшийн түүхэн мэдээлэл, ногдол ашгийн бодлого болон ногдол ашиг тараасан мэдээлэл, олон нийтийн хэвлэл мэдээлэлд гаргасан мэдэгдэл, хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах болон үнэт цаасны бүртгэл хариуцсан этгээдийн нэр, холбоо барих мэдээлэл зэргийг нийтэлнэ.

***Зөвлөмж 1.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.***

***Тайлбар 1.*** Хөрөнгө оруулагчдын оролцоог хангаж, тэдгээрийн санал бодлыг хүлээн авах, мэдээлэл солилцох хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байна;

***Тайлбар 2.*** Хөрөнгө оруулагчид болон бусад оролцогчдод өөрийн бизнес, засаглал, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх мэдээллийг хүргэнэ;

***Тайлбар 3.*** Хөрөнгө оруулагчдад ойлгомжтой, хялбар байдлаар мэдээллийг хүргэх, харилцах мэдээллийн цахим сувгийг хөгжүүлэн ашиглана.

***Зөвлөмж 1.3. Компани хувьцаа эзэмшигчдийнхээ ХЭХ-д оролцох, санал гаргах, санал хураалтад оролцох эрхийг хангана.***

***Тайлбар 1.*** ХЭХ хуралдуулах шийдвэр гаргах, хэлэлцэх асуудлын жагсаалтыг тогтоох, хурлын зар хүргүүлэх, хурлын бэлтгэл ажлыг хангах, холбогдох баримт, мэдээлэлтэй

ТӨСӨЛ 2022.02.21

урьдчилан судалж танилцах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгох, хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах, хурлыг удирдан явуулах санал хураах, хурлын шийдвэрийг баримтжуулах, хадгалах, тэмдэглэл хөтлөх, хувьцаа эзэмшигчдэд хурлын шийдвэр болон тэмдэглэлтэй танилцах боломжийг олгох зэрэг асуудлыг зохицуулсан ХЭХ зарлан хуралдуулах тусгайлсан журам батлан мөрдөнө;

**Тайлбар 2.** ХЭХ-ыг хувьцаа эзэмшигчдэд тохиромжтой цаг, байршилд зохион байгуулж, хурлын зарыг тодорхой байдлаар урьдчилан хүргүүлж, хуралд гүйцэтгэх удирдлагыг байлцуулна. Мөн зайны технологийг ашиглан цахимаар хуралд оролцох, саналаа өгөх дотоод зохицуулалт ба боломжийг бүрдүүлнэ.

**Зөвлөмж 1.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарна.**

**Тайлбар 1.** ТУЗ нь шинээр хөрөнгө татан төвлөрүүлэх арга замыг эрэлхийлэхдээ одоогийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувийг бууруулахгүй байхыг эрмэлзэнэ. Мөн нэмж хувьцаа гаргах тохиолдолд хувьцаа эзэмшигчдэд өөрийн хувь эзэмшилд хувь тэнцүүлэн худалдан авах боломжийг олгоно. Гэхдээ энэ зөвлөмж нь ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, эрх бүхий албан тушаалтанд урамшууллын журмаар хувьцаа олгох зэрэг нэмж хөрөнгө татахыг зориогүй тохиолдолд хамаарахгүй;

**Тайлбар 2.** Нэмж гаргасан үнэт цаасыг одоо байгаа хувьцаа эзэмшигчдээ хувь тэнцүүлэн худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ талаар эрх бүхий байгууллагад тайлан хүргүүлэх болон өөрийн цахим хуудсанд тайлбар хийнэ.

**Зөвлөмж 1.5. Компанийн болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг бичгээр боловсруулан баталж, нийтэд мэдээлнэ.**

**Тайлбар 1.** Сонирхлын зөрчилтэй хэлцлийг гагцхүү бичгээр хийх, хэлцэл хийх зөвшөөрлийг урьдчилан авч байх, хэлцлийг шударга, зах зээлийн үнээр хийх ба хийгдсэн хэлцлийн талаарх бүрэн мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд байршуулна;

**Тайлбар 2.** Ханган нийлүүлэлтийн сувгийг хамааралтай этгээд дангаар эзэгнэх, компанийн өмч хөрөнгийг шамшигдуулах, зүй бусаар шилжүүлэх, хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн хамааралтай этгээдэд компанийн нэрийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргаж өгөхөөс сэргийлнэ.

**ЗАРЧИМ 2. Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь олон талт үр чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг тэнцвэртэй агүүлсан, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.**

**Зөвлөмж 2.1. Компани нь ТУЗ болон ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан хуваарилж, тогтоосон бичмэл үйл ажиллагааны журамтай байх ба журамд ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг, эрх хэмжээг тусад нь тодорхой тусгана.**

**Тайлбар 1.** Зарим компанийн үйл ажиллагаанд ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын ажил үүргийн хуваарь тодорхой бус, мэдээлэл солилцоо, хамтын ажиллагаа, уялдаа муу байдал тохиолддог тул эдгээрийг тодорхой, зүй зохистойгоор томъёолсон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамтай байна. Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-өөс баталсан үнэт зүйлс, ёс

ТӨСӨЛ 2022.02.21

зүйн дүрэм, төсөв, эрсдэлийн хязгаарын хүрээнд компанийн стратегийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлнэ;

**Тайлбар 2.** ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд ТУЗ-ийн дарга болон гишүүдийн эрх, үүргийг нарийвчлан тодорхойлно. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ТУЗ-ийн гишүүдийг чиг үүргээ гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангах, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын хооронд харилцан хүндлэл, итгэлцэл дээр тулгуурласан ажил хэрэгч харилцааг үүсгэн бэхжүүлэх үүрэг хүлээнэ. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн хуралдааны хэлэлцэх асуудлыг баталж, асуудал тус бүрийг хэлэлцэж, шийдвэр гаргах хангалттай боломж, цаг хугацаагаар хангах үүрэгтэй;

**Тайлбар 3.** ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд ТУЗ-ийн гишүүд ямар асуудлаар болон ямар журмаар хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн зөвлөгөөг компанийн зардлаар авч болох талаар тодорхой тусгана. Ялангуяа, ТУЗ-ийн хараат бус гишүүдэд дээрх боломжийг энэ журмаар олгох нь тэдгээрийг ТУЗ-ийн гишүүнийхээ үүргийг зүй зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэхэд тустай.

**Зөвлөмж 2.2. Компани нь ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх, залгамж халааны бодлогын баримт бичиг, журамтай байна.**

**Тайлбар 1.** ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийг сонгохдоо тэдгээрийн ёс зүй, зан суртахуун, ажлын туршлага, мэргэжлийн ур чадвар, боловсрол, гэмт хэрэг үйлдэж байсан эсэх, шүүхээр тогтоосон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаарх мэдээллийг нэг бүрчлэн шалгана;

**Тайлбар 2.** ТУЗ-ийн гишүүнийг улируулан томилох асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурал (“ХЭХ”) -аар хэлэлцүүлэхдээ ТУЗ-ийн гишүүнээр ажилласан нийт хугацаа, өмнөх бүрэн эрхийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, ТУЗ-ийн гишүүний үнэлгээ бүхий бүрэн мэдээллийг танилцуулна;

**Тайлбар 3.** ТУЗ-ийн хараат бус гишүүнээр нэр дэвшиж буй этгээдийн хараат бус байдлыг хэрхэн тодорхойлсон талаар ХЭХ-д дэлгэрэнгүй танилцуулна;

**Тайлбар 4.** ТУЗ-ийн гишүүнээр нэр дэвшиж буй этгээд нь нэр дэвших хүсэлт, томилогдсон тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай цаг хугацааг зориулах боломжтой, хүсэл тэмүүлэл бий гэдгээ бичгээр илэрхийлнэ.

**Зөвлөмж 2.3. ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн бүртэй ажлын нөхцөл, эрх хэмжээ, чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгасан гэрээг бичгээр хийнэ.**

**Тайлбар 1.** Шинээр томилогдож буй ТУЗ-ийн гишүүн бүртэй түүний чиг үүрэг, цалин урамшуулал, хариуцлагын даатгал, хараат бус гишүүний хувьд хараат бус байдал алдагдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд мэдэгдэх болон компанийн мэдээлэлтэй харьцах дэг журам, нууцлалын үүрэг зэргийг тусгасан гэрээг бичгээр байгуулна;

**Тайлбар 2.** ТУЗ-ийн гишүүд компанийн ёс зүйн дүрэм, авлига, албан тушаалын гэмт хэргээс сэргийлэх, дотоод мэдээлэл эзэмшигчид хориглох үйл ажиллагаа зэрэг дотооддоо баталж мөрддөг бодлогын баримт бичгүүд, дотоод журмыг сайн мэддэг байж, дагаж мөрдөнө;

ТӨСӨЛ 2022.02.21

**Тайлбар 3.** Гүйцэтгэх удирдлага, багийн гишүүн бүртэй түүний эрх үүрэг, ажлын нөхцөл, бусад асуудлыг нарийвчлан зохицуулсан хөлсөөр ажиллах гэрээг бичгээр байгуулна.

**Зөвлөмж 2.4.**

**ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, ТУЗ-ийн хуралд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд дэлгэрэнгүйгээр байршуулна.**

**Тайлбар 1.** Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг тус бүр жилд нэг удаа тогтмол хугацаанд үнэлж, тайлагнана. Ингэхдээ тухайн ТУЗ-ийн гишүүний ажлын ур чадвар, ТУЗ-ийн хурлын ирц, компанийн үйл ажиллагаанд, ач холбогдолтой ажилд зарцуулсан цаг, гаргасан хичээл зүтгэл, үр дүнг дурдана;

**Тайлбар 2.** ТУЗ болон түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн гишүүдийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хөндлөнгийн этгээдээр гүйцэтгүүлж болно;

**Тайлбар 3.** ТУЗ-ийн даргын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг ТУЗ-ийн хараат бус гишүүн нь бусад гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарыг оролцуулан гүйцэтгэнэ.

**Зөвлөмж 2.5. Компани нь ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байна. Энэхүү бодлогын баримт бичиг нь ТУЗ-ийн гишүүдийн мэргэшил, боловсрол, ур чадвар, туршлагаас гадна хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.**

**Тайлбар 1.** ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримтад туссан зорилтын биелэлтийг жил бүр дүгнэж, компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон компанийн цахим хуудсанд байршуулна;

**Тайлбар 2.** ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд хүйсийн тэнцвэртэй байдлыг хадгалахыг зорино. Хүйсийн тэнцвэртэй байдал нь компанийн тогтвортой хөгжилд сайн нөлөөтэй болохыг баталсан олон улсын судалгаа бий тул дэлхийн олон орны компанийн засаглалын кодекст ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн эзлэх хувь гучаас доошгүй байхыг эрмэлзэхээр заах болжээ;

**Тайлбар 3.** Хүйсийн тэнцвэртэй байдлыг ТУЗ-өөр зогсохгүй, компанийн гүйцэтгэх удирдлага, ажилтнуудын түвшинд ч хадгалахыг эрмэлзэх нь зүйтэй. Иймд бүтэц, бүрэлдэхүүний бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх чиг үүргийг ТУЗ-ийн аль нэг (нэр дэвшүүлэх, эсвэл цалин урамшууллын) хороо хариуцна.

**Зөвлөмж 2.6. ТУЗ-ийн гишүүдийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба цаашид чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг мэдээллийг олгох сургалтад тогтмол хамруулна.**

**Тайлбар 1.** ТУЗ-ийн гишүүдийн мэдлэг, чадварыг тогтмол дээшлүүлэх, цаг үеийн шаардлагад нийцүүлэхэд компанийн зүгээс тодорхой хөтөлбөрийн дагуу зохих нөөцийг зарцуулж байх шаардлагатай.

**Зөвлөмж 2.7. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан ТУЗ-ийн өмнө хариуцлага хүлээнэ.**

ТӨСӨЛ 2022.02.21

**Тайлбар 1.** ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул түүнийг томилох, чөлөөлөх асуудал нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарна;

**Тайлбар 2.** ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлын чиг үүрэгт ТУЗ болон түүний дэргэдэх хороодод засаглалын асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, ТУЗ болон хороодын бодлогын баримт бичиг, дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавих, ТУЗ-ийн бичиг хэрэг, тэмдэглэл хөтлөх, ТУЗ-ийн хурал болон эрх бүхий албан тушаалтны сургалтыг тогтмол зохион байгуулах, зэрэг асуудлууд багтана.

### **ЗАРЧИМ 3. ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан хороодоор дамжуулан явуулж, эцсийн хариуцлагыг өөрөө хүлээнэ.**

**Зөвлөмж 3.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.**

**Тайлбар 1.** ТУЗ-ийн дарга нь хараат бус гишүүн байснаар ТУЗ-ийн үйл ажиллагаа илүү нээлттэй, олон ургалч үзлийг дэмжсэн уур амьсгал бүрдэх магадлал өндөр. ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын нөлөөнд бус, харин түүнийг чиглүүлэх, хянах зорилгоор хараат бус гишүүнээр удирдуулах нь зүйтэй;

**Тайлбар 2.** ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус байснаар ТУЗ-ийн шийдвэр гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн энгийн гишүүдийн ашиг сонирхлоос хамааралгүй, хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг дээдлэх магадлал өндөр. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь ТУЗ-ийн энгийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын оролцоогүйгээр уулзаж, хамтран зөвлөлдөх боломж, бололцоог бүрдүүлнэ.

**Зөвлөмж 3.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь бичмэл үйл ажиллагааны журамтай, дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.**

**Тайлбар 1.** Аудитын хороо нь компанийн аудитын зааврыг боловсруулж, ТУЗ-өөр батлуулах бөгөөд аудитын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, санхүүгийн тайлагналын чанарыг хангана;

**Тайлбар 2.** Аудитын хорооны дарга, гишүүд нь санхүүгийн тайлагналын зохих мэдлэг, туршлагатай байна. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд аудитын хорооны дүрэм болон аудитын заавар, аудитын хорооны бүрэлдэхүүний дэлгэрэнгүй мэдээлэл, хурлын давтамж, ирцийг нийтэд мэдээлнэ;

**Тайлбар 3.** Аудитын хорооны дарга нь компанийн хөндлөнгийн аудитортой аливаа холбоогүй, сүүлийн гурван жил тухайн хөндлөнгийн аудитын компанид ажиллаж байгаагүй байна;

**Тайлбар 4.** Компани нь Аудитын хорооноос эрсдэлийн удирдлагын чиг үүргийг салгаж, ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн хороог тусад байгуулах нь зохимжтой;

**Тайлбар 5.** Аудитын хорооны үйл ажиллагааны хараат бус байдлыг хангахын тулд компанийн гүйцэтгэх удирдлага, ажилтнуудыг зөвхөн тус хорооны хүсэлтээр хуралдаанд оролцуулна.

ТӨСӨЛ 2022.02.21

***Зөвлөмж 3.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь бичмэл үйл ажиллагааны журамтай байна. Цалин урамшууллын хорооны, дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.***

***Тайлбар 1.*** Цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг ХЭХ-аар, компанийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын бодлогыг боловсруулан ТУЗ-өөр тус тус батлуулна. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд цалин урамшууллын хорооны дүрэм болон цалин урамшууллын бодлогын баримт бичиг, хорооны бүрэлдэхүүний дэлгэрэнгүй мэдээлэл, хурлын давтамж, ирц, зэргийг нийтэд мэдээлнэ.

***Зөвлөмж 3.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь бичмэл үйл ажиллагааны журамтай байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна.***

***Тайлбар 1.*** Нэр дэвшүүлэх хороо нь нэр дэвшүүлэх бодлогыг боловсруулж ТУЗ-өөр батлуулна. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд нэр дэвшүүлэх хорооны дүрэм болон бодлогын баримт бичиг, хурлын давтамж, ирц зэргийг нийтэд мэдээлнэ;

***Тайлбар 2.*** Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын залгамж халааны бодлогын баримт бичиг, төлөвлөгөөг боловсруулан ТУЗ-өөр батлуулж хэрэгжүүлэх, ТУЗ-ийн гишүүдийг сургах, мэргэжил дээшлүүлэх асуудлыг хариуцаж, ТУЗ-ийн гишүүд болон бусад эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, туршлага нь ажлын шаардлагыг хангаж байгаа эсэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хараат бус байдал зэргийг тогтооно.

***Зөвлөмж 3.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий хороодыг байгуулж болно. ТУЗ-ийн хороод бүгд бичмэл үйл ажиллагааны журамтай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, туршлагатай бүрэлдэхүүнтэй байна.***

***Тайлбар 1.*** Компанийн үйл ажиллагааны онцлогоос хамааран ТУЗ-ийн дэргэд, эрүүл мэнд, аюулгүй байдлын, байгаль орчны гэх мэт байнгын болон түр хороог байгуулж болно;

***Тайлбар 2.*** ТУЗ-ийн дэргэдэх бусад хороодын үйл ажиллагааны журам, бодлогын баримт бичиг, гишүүдийн мэдээлэл, хурлын давтамж, ирц зэргийг жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар нийтэд мэдээлнэ. Эдгээр хороод нь үйл ажиллагаагаа ТУЗ-д улирал бүр тайлагнана;

***Тайлбар 3.*** Бусад этгээдээс компанийн хувьцааг бүхэлд нь буюу хяналтын багцаас дээш хувийг худалдан авах санал ирсэн тохиолдолд энэ асуудлыг зохицуулах ТУЗ-ийн дэргэдэх түр хороог байгуулж, уг хороо нь хараат бус ажиллаж, хөндлөнгийн зөвлөх, шинжээчдээр гаргуулсан тайланг хувьцаа эзэмшигчдэд танилцуулна.

- **ЗАРЧИМ 4. ТУЗ нь компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангах арга хэмжээг авна.**

***Зөвлөмж 4.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.***

ТӨСӨЛ 2022.02.21

**Тайлбар 1.** Хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд хүргэх мэдээллийг цаг хугацаанд нь, бодитой, эерэг болон сөрөг мэдээллийг багтаасан тэнцвэртэй байдлаар хүргэнэ;

**Тайлбар 2.** Компанийн тогтмол болон тухай бүр мэдээлэх, тайлагнах талаарх журмыг цахим хуудсандаа байршуулна;

**Тайлбар 3.** Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журамд компанийн эрх бүхий албан тушаалтнууд, ажилтнуудын хүлээх үүрэг, мэдээллийн нууцлал, түүнийг боловсруулах, нийтэд мэдээлэх, тайлагнах, хөрөнгө оруулагчид болон олон нийттэй харилцах, үнэт цаасны арилжаа, бүртгэлийн мэдээлэлд алдаа, зөрүү гарсан бол түүнийг залруулах ажиллагааг тусгаж, зохицуулсан байна.

**Зөвлөмж 4.2. Компанийн ёс зүйн дүрэм, ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам, энэхүү кодекст заасан болон засаглалын бусад чухал баримт бичгүүдийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ.**

**Тайлбар 1.** Компанийн цахим хуудсанд үйл ажиллагааны үндсэн мэдээлэл болон засаглалын бодлогын баримт бичгүүд, дотоод журмаа байршуулах нь хөрөнгө оруулагч, бусад оролцогч этгээдэд чухал ач холбогдолтой тул эдгээр мэдээллийг бүрэн бүтэн, танилцахад дөхөмтэй хэлбэрээр байршуулахаас гадна цаг тухайд нь шинэчлэн нийтэд мэдээлнэ.

**Зөвлөмж 4.3. Санхүүгийн тайлагнал болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодитой байна. Санхүүгийн бус мэдээллийн тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрэн эсэхийг үнэлсэн байна.**

**Тайлбар 1.** Санхүүгийн тайлагналыг улиралд, санхүүгийн бус тайлагналыг жилд нэгээс доошгүй удаа, тогтмол хийнэ;

**Тайлбар 2.** Санхүүгийн тайлагналыг хуульд заасан хугацаа, агуулга, хэлбэрээр бодитоор илэрхийлж, хангалттай, бүрэн тайлбарыг дагуулбал зохино. Хөрөнгө оруулагчдад бизнесийн загвар, гүйцэтгэл, стратегийн зорилтууд, тэдгээрийн биелэлтийн талаар тэнцвэртэй, ойлгомжтой мэдээлэл маш хэрэгтэй байдаг. Мөн тайлагналын аргад өөрчлөлт орсон бол тэр талаар тайлбар хийж, өмнөх хугацааны тайлантай харьцуулах боломжоор хангана;

**Тайлбар 3.** Санхүүгийн бус мэдээллийн тайланд орчны, нийгмийн, засаглалын хүчин зүйлсээс гадна компанийн стратегийн зорилтуудад хүрэхэд ямар үр дүн гаргаж буй талаарх мэдээллийг багтаана.

- **ЗАРЧИМ 5. ТУЗ нь компанийн аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнт байдлыг хангана.**

**Зөвлөмж 5.1. ТУЗ нь өөрийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.**

ТӨСӨЛ 2022.02.21

**Тайлбар 1.** Аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитыг сонгох шалгуур, аудитын хараат бус байдалд учирч болзошгүй эрсдэл, түүнийг хэрхэн удирдах талаар тусгана;

**Тайлбар 2.** Аудитын хороо, гүйцэтгэх удирдлага, хөндлөнгийн аудиторын хооронд тогтмол мэдээлэл, санал солилцох арга хэлбэр, зохион байгуулалтыг аудитын хорооны үйл ажиллагааны журамд тусгана;

**Тайлбар 3.** Хөндлөнгийн аудитороос компанид үзүүлж болох хуулиар тогтоосноос бусад үйлчилгээг Аудитын хороо баталж, түүнд хяналт тавина.

**Зөвлөмж 5.2.** Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, өөрийн хийж гүйцэтгэсэн аудиттай холбоотой хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулдаг байна.

**Тайлбар 1.** Хувьцаа эзэмшигчдэд тухайн аудитыг хийж гүйцэтгэсэн хөндлөнгийн аудитороос асуулт асууж, хариулт авах боломж, бололцоог бүрдүүлсэн байна.

**Зөвлөмж 5.3.** Компанийн дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол мэдээлнэ. Хэрэв бие даасан дотоод аудитын бүтэцгүй бол засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоогоо үнэлэх, хянах, сайжруулах үйл ажиллагааныхаа талаар тайлбар гаргана.

**Тайлбар 1.** Дотоод аудитын тогтолцоо нь компанийн эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг тогтмол хянах, үр дүнг нь сайжруулах замаар урт хугацааны тогтвортой өсөлт, хөгжилд чухал хувь нэмэр оруулна;

**Тайлбар 2.** Дотоод аудитын нэгжийн удирдлага нь зохих мэдлэг, чадвар, туршлагатай байх ба ТУЗ, эсвэл ТУЗ-ийн дэргэдэх холбогдох хороотой шууд харилцаж, тайлагнана.

- **ЗАРЧИМ 6. ТУЗ нь эрсдэлийн удирдлагын болон комплайнсын хяналтын тогтолцоог зүй зохистой, хараат бусаар зохион байгуулж, үр дүнт байдлыг тогтмол хянана.**

**Зөвлөмж 6.1.** Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.

**Тайлбар 1.** ТУЗ-ийн бүрэлдэхүүн компанид учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, түүнийг хэрхэн удирдах талаар бодит, бүрэн ойлголттой байх шаардлагатай.

**Зөвлөмж 6.2.** ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.

**Тайлбар 1.** Компанийн үйл ажиллагааны чиглэл, хэмжээ, бизнесийн онцлогоос хамаарч учирч болох эрсдэл харилцан адилгүй тул ТУЗ нь компанийн зорилго, алсын хараатай уялдуулан хүлээж болох эрсдэлийн төрөл, хэмжээ хязгаарыг тодорхойлох чиг үүргийг хэрэгжүүлнэ;

ТӨСӨЛ 2022.02.21

**Тайлбар 2.** Эрсдэлийн хороо нь компанийн эрсдэлийн удирдлагыг тогтмол хянаж, эрсдэлийг хянах, илрүүлэх доотод хяналтын тогтолцооны үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, холбогдох зөвлөмжийг ТУЗ-д танилцуулна;

**Тайлбар 3.** Компанид тулгарч байгаа эрсдэл, тэдгээрийг хэрхэн удирдаж байгаа талаар бүрэн гүйцэд мэдээллийг гүйцэтгэх удирдлагаас Эрсдэлийн хороонд тогтмол хүргүүлэн заавар, удирдамж авч байх харилцааг нэвтрүүлсэн байна;

**Тайлбар 4.** Эрсдэлийн хорооны чиг үүргийг аудитын хороонд хариуцуулж болох ба энэ тохиолдолд эрсдэлийн удирдлагын тогтолцоо, журам, хэрэгжилтийн талаарх мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд тайлбарлана.

**Зөвлөмж 6.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.**

**Тайлбар 1.** Байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын хүрээний эрсдэлүүд нь компанийн урт хугацааны тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлнө. Тиймээс хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын хувьд эдгээр эрсдэлийг бүрэн мэдэж, үнэлэх нь чухал;

**Тайлбар 2.** Компани нь энэ зөвлөмжид дурдсан мэдээллийг тайлагнахдаа заавал бие даасан тогтвортой байдлын тайлан гаргах албагүй боловч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу тогтвортой байдлын тайлан гаргадаг бол түүнийгээ эш татах замаар энэхүү кодексийн шаардлагыг хангаж болно.

**Зөвлөмж 6.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.**

**Тайлбар 1.** ТУЗ-өөс комплайнсын хяналтын үйл ажиллагааны журам, жил бүрийн төсвийг батлан хүний нөөцийг томилж, шууд харьцана.

**Тайлбар 2.** ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь комплайнсын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээдэд шаардлагатай туслалцаа, дэмжлэгийг үзүүлж, бие даасан хараат бус байдлыг хангана.

- **ЗАРЧИМ 7. Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.**

**Зөвлөмж 7.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг ХЭХ-аар ил тод хэлэлцэж батална.**

**Тайлбар 1.** ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж батлахдаа хэмжээг тодорхой илэрхийлж, үндэслэлийг ойлгомжтой тайлбарлана. Цалин, урамшууллыг ТУЗ-ийн нийт цалингийн сан бус, ТУЗ-ийн гишүүн бүрээр, мөн хэрэв ТУЗ-ийн аливаа хорооны гишүүний хувиар хийсэн ажилд тусад нь цалин урамшуулал олгох бол түүнийг тодорхой заана;

**Тайлбар 2.** ТУЗ-ийн гишүүдэд бодитоор олгосон цалин, урамшууллын хэмжээг жилийн тайланд тодорхой тусгана. Ингэхдээ албан ёсны ТУЗ-ийн гишүүний цалингаас гадна ТУЗ-

ТӨСӨЛ 2022.02.21

ийн дэргэдэх аливаа хорооны гишүүний хувиар, эсвэл компанитай хийсэн бусад гэрээ хэлцлийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын цалин хөлсийг оруулж, дэлгэрэнгүйгээр задлан харуулна.

***Зөвлөмж 7.2. Компани цалин, урамшууллын бодлогын баримт бичигтэй байх ба түүнд цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг тусгана.***

***Тайлбар 1.*** Цалин, урамшууллын бодлого нь цалин, урамшууллын түвшинг шударга, үндэслэл бүхий, тухайн компанийн үйл ажиллагааны чиглэл, хэмжээ, онцлогт тохируулан зах зээлд өрсөлдөхүйц хэмжээнд тогтоохыг эрмэлзсэн байна;

***Тайлбар 2.*** Цалин, урамшууллын хэмжээг тогтоох арга ил тод байна. Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллыг тогтоохдоо ТУЗ нь мэргэшсэн, хараат бус зөвлөхийн зөвлөгөөг авч болно. Хараат бус зөвлөх гэж компанийн эрх бүхий албан тушаалтан болон зөвлөх үйлчилгээний үр дүн ашиг сонирхолд нь тодорхой хэмжээгээр нөлөөлж болзошгүй аливаа этгээдээс хараат бус байх этгээдийг хэлнэ;

***Тайлбар 3.*** Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллыг ялгавартай тогтоох нь зүйтэй. Цалин, урамшууллын бодлогод гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллыг тогтоох үндсэн зарчмуудыг тусгаж, ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллыг давхар олгох бол тэр тухай тусгайлан заасан байна. Мөн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүний цалин, урамшууллыг компанийн ашиг орлого, тухайн этгээдийн ажлын гүйцэтгэлтэй уялдуулсан байна.

***Зөвлөмж 7.3. Компанийн үйл ажиллагааны жилийн тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.***

***Тайлбар 1.*** Хувьцаа эзэмшигчдэд гүйцэтгэх удирдлагад бодитоор олгосон цалин, урамшууллын дүнгийн мэдээллийг ил тод байлгана. Цалин, урамшууллын бодлогод гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын бүрэлдэхүүн хэсгүүд (үндсэн цалин, богино болон урт хугацааны шагнал, урамшуулал зэрэг)-ийг тоймлон тусгана;

***Тайлбар 2.*** Компанийн эрх бүхий албан тушаалтнуудад олгосон хувьцаа болон хувьцаанд хөрвөх опцион зэрэг урт хугацааны шагнал, урамшуулал болон тэдгээрийн хэрэгжих нөхцөлийн талаарх бүрэн мэдээллийг нийтэд ил тод байлгана;

***Тайлбар 3.*** Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын мэдээллийг жилийн тайланд тусгахдаа өмнөх жилтэй харьцуулж болохуйц байдлаар илэрхийлнэ. Мөн хувьцаа болон хувьцаанд хөрвөх опцион зэрэг урт хугацааны шагнал, урамшууллын гүйцэтгэлийг жил бүр тайлагнана;

***Тайлбар 4.*** Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын талаар нийтэд мэдээлэхдээ өөрөөс нь тухай бүр зөвшөөрлийг авах, эсвэл хөдөлмөрийн гэрээндээ энэ талаар заах нь зүйтэй.

- **ЗАРЧИМ 8. Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ.**

***Зөвлөмж 8.1. Компани бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдлөг болгоно. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь***

ТӨСӨЛ 2022.02.21

**оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.**

**Тайлбар 1.** Компанийн тогтвортой өсөлтийг хангах, дунд болон урт хугацаанд үнэ цэнийг бий болгоход бусад оролцогч талуудын хувь нэмрийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай;

**Тайлбар 2.** Компанийн хөгжлийн стратегийг хариуцдаг чиглүүлэгч бүтцийн хувьд ТУЗ нь оролцогч талуудын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, тэдгээрийг зохистойгоор тэнцвэржүүлэн ажиллана.

**Зөвлөмж 8.2. Компанийн үйл ажиллагааны жилийн тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.**

**Тайлбар 1.** Оролцогч талуудтай үр дүнтэй харилцаа холбоо үүсгэхийн тулд олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэн санхүүгийн бус мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.

**Зөвлөмж 8.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэй ажиллуулна.**

**Зөвлөмж 8.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх ажлын төлөвлөгөөтэй байна.**

- **ЗАРЧИМ 9. ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно.**

**Зөвлөмж 9.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, хэрэгжүүлж, нийтэд мэдээлнэ.**

**Тайлбар 1.** Компани урт хугацааны туршид үнэ цэнээ өсгөж, хадгалж явахын тулд үйл ажиллагаандаа эрх зүй, ёс зүй, мэргэжлийн хариуцлагын тодорхой хэм хэмжээг баримтална. Компани өөрийн харилцагч, ханган нийлүүлэгч, зээлдүүлэгч, ажилтнууд, хяналт, зохицуулагчдын дунд бизнесийн нэр хүнд, хүндэтгэлийг бэхжүүлж хамгаалах талаар тодорхой арга хэмжээг хэрэгжүүлнэ;

**Тайлбар 2.** Компанийн үнэт зүйлс болон ёс зүйн дүрмийг ТУЗ баталж, гүйцэтгэх удирдлага нь байгууллагад нэвтрүүлж, хэрэгжүүлэх ажлыг хариуцна. Үүнд гүйцэтгэх удирдлагаас чадваржуулах дотоод сургалтыг тогтмол зохион байгуулах, өөрийн үлгэр дуурайллаар хандлагыг хэвшүүлнэ;

**Тайлбар 3.** Ёс зүйн дүрмийн хэрэгжилт, илэрсэн ёс зүйн зөрчил, тэдгээрийг шийдвэрлэсэн явцыг ТУЗ-өөс тогтмол хугацаанд хянан үзэж шаардлагатай шинэчлэл, өөрчлөлтийг хийнэ.

**Зөвлөмж 9.2. Хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ эсвэл ТУЗ-ийн холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.**

**Тайлбар 1.** Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээг ёс зүйн дүрэмд тусгаж, тэдгээрийг зөрчсөн тохиолдолд зөрчлийг

ТӨСӨЛ 2022.02.21

мэдээлэх, хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлж, шаардлагатай тохиолдолд шинэчилнэ;

**Тайлбар 2.** Компанийн үнэт зүйлсийг үл хүндэтгэсэн, ёс зүйгүй, хариуцлагагүй, эсхүл хууль бус үйлдлийн талаарх мэдээллийг ТУЗ, эсвэл ТУЗ-ийн холбогдох хороонд мэдээлэх, хариуцлага тооцох боломжийг ТУЗ бүрдүүлсэн байна. Мөн мэдээлэл өгсөн этгээд буюу “шүгэл үлээгч”-ийн нууцлалыг хадгалах, түүний нэр хүнд, цалин урамшуулал, ажлын байрыг нь хамгаалах зохицуулалтыг нэвтрүүлнэ;

**Тайлбар 3.** ТУЗ нь Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудад “шүгэл үлээх” тогтолцоо, түүний дагуу мэдээллийг хэрхэн өгөх, авах, шийдвэрлэх талаар тогтмол сургалт зохион байгуулна.

**Зөвлөмж 9.3. Ёс зүйн дүрэмд авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, хандив өргөх талаар зохицуулсан байна.**

**Тайлбар 1.** Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд төрийн албан хаагчдад зүй бус шагнал, урамшуулал буюу авлига өгөх нь эрүүгийн гэмт хэрэг бөгөөд компанийн нэр хүндэд ихээхэн хортой үйлдэл. Иймд ТУЗ нь авилгын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох ажилтнуудыг зохих сургалтад тогтмол хамруулна;

**Тайлбар 2.** ТУЗ нь улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн үйл ажиллагаа явуулж буй байгууллага, иргэнд хандив өгөх, дэмжлэг илэрхийлэх үйл явцад хяналт тавина.

- **ЗАРИМ НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР**

Энэхүү кодекст орсон доорх нэр томъёог дараах утгаар ойлгоно:

- “Хөрөнгө оруулагч” гэж хувьцаа, бонд зэрэг компанийн гаргасан үнэт цаасыг эзэмшигч, эсвэл эзэмшигч болохыг сонирхож буй этгээдийг;
- “ТУЗ-ийн хараат бус гишүүн” гэж Монгол Улсын Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт заасан шалгуураас гадна компанийн томоохон хувьцаа эзэмшигчээс хараат бус ТУЗ-ийн гишүүнийг;
- “Томоохон хувьцаа эзэмшигч” гэж компанийн саналын эрх бүхий энгийн хувьцааны 10 болон түүнээс дээш хувийг эзэмшигчийг;
- “Оролцогч талууд” гэж тухайн компанийн ажилтан, зээлдүүлэгч, харилцагч, ханган нийлүүлэгч, компанийн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэнийг.

Кодексийн нэр томъёоны тайлбарт ороогүй бусад нэр томъёог Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тодорхойлж, хэрэглэж заншсанаар ашигласан болно.

*Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ний ....  
тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хавсралт 1*

**Компанийн засаглалын үйл ажиллагааны тайлангийн маягт**

“Компанийн засаглалын кодекс”-ийн зарчим, зөвлөмжийн дагуу үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэнэ.

*Кодексийн хэрэгжилтийг олон улсад түгээмэл тогтсон “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнахдаа кодекст дурдсан зөвлөмжүүдийг биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсныг тайлбар хэсэгт нарийвчлан тайлбарлана.*

<i>Жич: Хэрэгжилт болон тайлбарыг зөвлөмж тус бүрээр гаргана.</i>		
<b>ЗАРЧИМ 1. Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, шаардлагатай мэдээлэл болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана</b>		
	Хэрэгжилт	Тайлбар
1	<i>Зөвлөмж 1.1. Хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан компанийн үйл ажиллагаа, санхүү, засаглалын зохион байгуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан хүргэнэ.</i>	
	Хэрэгжилт	Тайлбар
2	<i>Зөвлөмж 1.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</i>	
	Хэрэгжилт	Тайлбар
3	<i>Зөвлөмж 1.3. Компани хувьцаа эзэмшигчдийнхээ ХЭХ-д оролцох, санал гаргах, санал хураалтад оролцох эрхийг хангана.</i>	
	Хэрэгжилт	Тайлбар
4	<i>Зөвлөмж 1.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарна.</i>	
	Хэрэгжилт	Тайлбар
5	<i>Зөвлөмж 1.5. Компанийн болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг бичгээр боловсруулан баталж, нийтэд мэдээлнэ.</i>	
<b>ЗАРЧИМ 2. Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг тэнцвэртэй агуулсан, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна</b>		
	Хэрэгжилт	Тайлбар
6	<i>Зөвлөмж 2.1. Компани нь ТУЗ болон ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, харуцлагыг нарийвчлан хуваарилж, тогтоосон бичмэл үйл ажиллагааны журамтай байх ба журамд ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг, эрх хэмжээг тусад нь тодорхой тусгана.</i>	
	Хэрэгжилт	Тайлбар
7	<i>Зөвлөмж 2.2. Компани нь ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгауулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх, залгамж халааны бодлогын баримт бичиг, журамтай байна.</i>	

		Хэрэгжилт	Тайлбар
8	<i>Зөвлөмж 2.3. ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн бүртэй ажлын нөхцөл, эрх хэмжээ, чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгасан гэрээг бичгээр хийнэ.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
9	<i>Зөвлөмж 2.4. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршилага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, ТУЗ-ийн хуралд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд дэлгэрэнгүйгээр байршуулна.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
10	<i>Зөвлөмж 2.5. Компани нь ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байна. Энэхүү бодлогын баримт бичиг нь ТУЗ-ийн гишүүдийн мэргэшил, боловсрол, ур чадвар, туршилагаас гадна хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
11	<i>Зөвлөмж 2.6. ТУЗ-ийн гишүүдийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба цаашид чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг мэдээллийг олгох сургалтад тогтмол хамруулна</i>		
<b>ЗАРЧИМ 3. ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан хороодоор дамжуулан явуулж, эцсийн хариуцлагыг өөрөө хүлээнэ</b>			
		Хэрэгжилт	Тайлбар
12	<i>Зөвлөмж 3.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
13	<i>Зөвлөмж 3.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь бичмэл үйл ажиллагааны журамтай, дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
14	<i>Зөвлөмж 3.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь бичмэл үйл ажиллагааны журамтай байна. Цалин урамшууллын хорооны, дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар

ТӨСӨЛ 2022.02.21

15	<i>Зөвлөмж 3.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь бичмэл үйл ажиллагааны журамтай байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
16	<i>Зөвлөмж 3.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий хороодыг байгуулж болно. ТУЗ-ийн хороод бүгд бичмэл үйл ажиллагааны журамтай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, туршлагатай бүрэлдэхүүнтэй байна.</i>		
<b>ЗАРЧИМ 4. ТУЗ нь компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангах арга хэмжээг авна</b>			
		Хэрэгжилт	Тайлбар
17	<i>Зөвлөмж 4.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>		
18	<i>Зөвлөмж 4.2. Компанийн ёс зүйн дүрэм, ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам, энэхүү кодекс заасан болон засаглалын бусад чухал баримт бичгүүдийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
19	<i>Зөвлөмж 4.3. Санхүүгийн тайлагнал болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодитой байна. Санхүүгийн бус мэдээллийн тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн байна.</i>		
<b>ЗАРЧИМ 5. ТУЗ нь компанийн аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнт байдлыг хангана</b>			
		Хэрэгжилт	Тайлбар
20	<i>Зөвлөмж 5.1. ТУЗ нь өөрийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
21	<i>Зөвлөмж 5.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, өөрийн хийж гүйцэтгэсэн</i>		

ТӨСӨЛ 2022.02.21

	<i>аудиттай холбоотой хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулдаг байна.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
22	<i>Зөвлөмж 5.3. Компанийн дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол мэдээлнэ. Хэрэв бие даасан дотоод аудитын бүтэцгүй бол засаглал, эрсдэлийн удирдлага, дотоодын хяналтын тогтолцоогоо үнэлэх, хянах, сайжруулах үйл ажиллагааныхаа талаар тайлбар гаргана.</i>		
<b>ЗАРЧИМ 6. ТУЗ нь эрсдэлийн удирдлагын болон комплайнсын хяналтын тогтолцоог зүй зохистой, хараат бусаар зохион байгуулж, үр дүнт байдлыг тогтмол хянана</b>			
		Хэрэгжилт	Тайлбар
23	<i>Зөвлөмж 6.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
24	<i>Зөвлөмж 6.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
25	<i>Зөвлөмж 6.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
26	<i>Зөвлөмж 6.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>		
<b>ЗАРЧИМ 7. Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна</b>			
		Хэрэгжилт	Тайлбар
27	<i>Зөвлөмж 7.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг ХЭХ-аар ил тод хэлэлцэж батална.</i>		

		Хэрэгжилт	Тайлбар
28	<i>Зөвлөмж 7.2. Компани цалин, урамшууллын бодлогын баримт бичигтэй байх ба түүнд цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг тусгана.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
29	<i>Зөвлөмж 7.3. Компанийн үйл ажиллагааны жилийн тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>		
<b>ЗАРЧИМ 8. Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ</b>			
		Хэрэгжилт	Тайлбар
30	<i>Зөвлөмж 8.1. Компани бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдлөг болгоно. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
31	<i>Зөвлөмж 8.2. Компанийн үйл ажиллагааны жилийн тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
32	<i>Зөвлөмж 8.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэй ажиллуулна.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар
33	<i>Зөвлөмж 8.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх ажлын төлөвлөгөөтэй байна.</i>		
<b>ЗАРЧИМ 9. ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно</b>			
		Хэрэгжилт	Тайлбар
34	<i>Зөвлөмж 9.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, харуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, хэрэгжүүлж, нийтэд мэдээлнэ.</i>		
		Хэрэгжилт	Тайлбар

ТӨСӨЛ 2022.02.21

35	Зөвлөмж 9.2. Хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ эсвэл ТУЗ-ийн холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.		
		Хэрэгжилт	Тайлбар
36	Зөвлөмж 9.3. Ёс зүйн дүрэмд авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, хандив өргөх талаар зохицуулсан байна.		
<p><i>Санамж:</i> Компани нь засаглалын зарчмуудыг Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн бүх хуулийн этгээд хэрэгжүүлнэ. Тухайлбал, МХБ-ийн 1-р ангилалд бүртгэлтэй ХК нь кодексийн зөвлөмж бүрээр энэхүү маягтын дагуу хэрэгжилт, эсхүл тайлбарыг бүрэн, МХБ-ийн 2-р ангилалд бүртгэлтэй ХК нь кодексийн зөвлөмжүүдийн 95 хувийг хангасан хэрэгжилт, эсхүл тайлбарыг тайлагнана. Хэрэв дээр дурдсан шалгуурыг хангаагүй буюу хэрэгжүүлээгүй эсвэл тайлбарлаагүй тохиолдолд Тухайн ХК-ийн МХБ-ийн бүртгэлийн ангиллыг бууруулах үндэслэл болох ба нөгөө талаас хөрөнгө оруулагч шийдвэр гаргахад нөлөөлөх шалтгаан болохыг анхаарна уу.</p>			

*Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ний .... тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хавсралт 2*

## **“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

### **НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэхүү Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийн зорилго нь компанийн дотооддоо мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг “Компанийн засаглалын кодекс”-ийн зарчимд нийцүүлэн баталгаажуулах, дагаж мөрдсөнөөр компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэвшил болгоход оршино.

### **ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **2.1.Хөтөлбөрийн зорилт:**

- 2.1.1.хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах;
- 2.1.2.төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/ болон гүйцэтгэх удирдлагын хариуцлагын тогтолцоог олон улсын жишигт хүргэх;
- 2.1.3.тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах;
- 2.1.4.эрсдэлийн удирдлагыг сайжруулах;

ТӨСӨЛ 2022.02.21

2.1.5.хяналтын тогтолцоог сайжруулах.

2.2.Хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.2.1.Компанийн тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, “Компанийн засаглалын кодекс”-д тусгагдсан бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг компанийн засаглалын үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн мөрдүүлэх;

2.2.2.компанийн бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд комплайнсын хяналтыг тогтмол хэрэгжүүлэх;

2.2.3.эрх бүхий албан тушаалтнуудыг компанийн засаглалын сургалтад хамруулах;

2.2.4.хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, мэдээлэх.

### ГУРАВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1.Энэхүү хөтөлбөрийг компанийн ТУЗ нь өөрийн байгууллагын бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцүүлэн баталж, бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд нь хяналт тавина.

3.2. ТУЗ нь дараах бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг баталж, мөрдөнө:

3.2.1.дүрэм, бодлогын баримт бичиг, дүрэм, заавар болон бусад:

3.2.1.1.ёс зүйн дүрэм;

3.2.1.2.залгамж халааны бодлого;

3.2.1.3.цалин, урамшууллын бодлого;

3.2.1.4.ногдол ашгийн бодлого;

3.2.1.5.эрсдэлийн удирдлагын заавар;

3.2.1.6.дотоод аудитын заавар;

3.2.1.7.дотоод хяналтын заавар;

3.2.1.8.комплайнсын хяналтын заавар;

3.2.1.9.холбогдох хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, дотооддоо мөрдөх стандарт, аргачлалыг багтаасан бусад баримт бичиг.

3.2.2.дотоод журам:

3.2.2.1.хувьцаа эзэмшигчдийн хурлын журам;

3.2.2.2.ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;

3.2.2.3.ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам;

3.2.2.4.ТУЗ-ийн дэргэдэх холбогдох хороодын үйл ажиллагааны журам;

3.2.2.5.гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам;

3.2.2.6.мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;

3.2.2.7.эрсдэлийн удирдлага, дотоод аудит, дотоод хяналт, комплайнсын нэгж, эсхүл ажилтны үйл ажиллагааны бусад шаардлагатай журам.

### ДӨРӨВ.ТАЙЛАГНАЛ, ҮНЭЛГЭЭ

4.1.ТУЗ нь байгууллагын дүрэм, бодлогын баримт бичиг, заавар, журам, загварыг боловсруулах, мөрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, явцын талаар жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнана.

4.2. ТУЗ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, компанийн засаглалын үнэлгээг компанийн үйл ажиллагааны тайланд тусгаж, компанийн цахим хуудсанд байршуулна.

4.3. ТУЗ нь жил бүрийн эхний улиралд багтааж, компанийн засаглалыг үнэлэх асуулгын дагуу өөрийн компанийн засаглалын түвшинг үнэлж болно.

ТӨСӨЛ 2022.02.21

4.4.ТУЗ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалын хамт Хороонд хүргүүлнэ.

1

*Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ний ....  
тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хавсралт 2*

## **ЁС ЗҮЙН ДҮРМИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

### **НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэхүү ёс зүйн дүрмийн зорилго нь компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоож ,түүнийг мөрдүүлэх, хэвшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Дүрэмд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1.“компанийн ашиг сонирхол” гэж компанийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр, дүрэм, журам, шийдвэрт нийцсэн эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;

1.2.2.“хувийн ашиг сонирхол” гэж албан үүргээ гүйцэтгэхдээ өөрөө болон хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;

1.2.3.“давуу байдал” гэж нэр төр, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд бий болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

1.2.4.”эрх бүхий албан тушаалтан” гэж төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, Хорооноос заасан бусад албан тушаалтныг.

## ХОЁР. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1.Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь ажил, үүрэг гүйцэтгэхдээ холбогдох хууль, тогтоомж, энэхүү дүрэм болон дараах ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:

- 2.1.1.үйл ажиллагаандаа хууль тогтоомж, дүрэм, журмыг чандлан мөрдөнө;
- 2.1.2.үйл ажиллагаагаа шударга, ил тод, нээлттэй байдлаар явуулна;
- 2.1.3.хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч, харилцагч, бэлтгэн нийлүүлэгч, хэрэглэгч, ажилтнууд зэрэг оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэнэ;
- 2.1.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг эрхэмлэнэ;
- 2.1.5.ажилтан бүрд эрх тэгш, хүндэтгэлтэй хандан аюулгүй байдалд ажиллах орчныг бүрдүүлнэ;
- 2.1.6.олон талт оролцоо, багийн ажиллагааг хөгжүүлсэн харилцан итгэлцэл, хүндлэл бүхий хамтын ажиллагааг эрхэмлэнэ;
- 2.1.7.компанийн нэр хүнд, өмч хөрөнгийг хамгаална;
- 2.1.8.байгууллагын нууц болон үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн хувь хүний нууцыг холбогдох хуульд заасны дагуу хамгаална.

2.2.ТУЗ-ийн дарга, гишүүний ёс зүйн хэм хэмжээ:

- 2.2.1.хууль тогтоомж, хувьцаа эзэмшигчдийн хурал, компанийн дүрэм болон ТУЗ-ийн шийдвэрээр тогтоосон эрх, үүргээ энэхүү дүрэмд заасан ёс зүйн зарчимд бүрэн нийцүүлэх;
- 2.2.2.байгууллагын соёлыг хөгжүүлэх;
- 2.2.3.хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хангах;
- 2.2.4.компанийн аливаа шийдвэр, үйл ажиллагаанд хувийн сонирхлоор хандахгүй, албан тушаалын давуу байдал үүсгэхгүй байх;
- 2.2.5.бусдад хүндлэлтэй хандах;
- 2.2.6.дотоод мэдээллийг хууль бусаар ашиглахгүй, задруулахгүй байх;
- 2.2.7.эрх үүргээ хэрэгжүүлэхдээ хичээл зүтгэл гаргаж ажиллах;
- 2.2.8.аливаа асуудалд үндэслэлтэй, шударга хандах;
- 2.2.9.өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг компанийн эрх бүхий албан тушаалтанд гаргаж өгөх;
- 2.2.10.сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэж, тухайн асуудлаар санал хураалтад оролцохгүй байх;
- 2.2.11.өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, ажилтны мэдлэг, чадварыг байнга хөгжүүлэх;
- 2.2.12.энэ дүрмийг зөрчих үйлдэл, эс үйлдлээс татгалзах, шаардлагатай тохиолдолд бүрэн эрхээсээ татгалзах ёс зүйтэй байх.

2.3.Гүйцэтгэх удирдлагын ёс зүйн хэм хэмжээ:

- 2.3.1.компанийн дүрэм, журам, гэрээнд заасан эрх үүргээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг баримтах;
- 2.3.2.үйл ажиллагаагаа шударга, ил тод, нээлттэй байдлаар явуулах;
- 2.3.3.ажилтны саналыг сонсож, харилцан уялдаа бүхий эргэх холбоотой ажиллах;
- 2.3.4.компанийн нэрийн өмнөөс оролцогчидтой харилцахдаа ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;
- 2.3.5.албан үүргээ гүйцэтгэхдээ хамт олонтойгоо эелдэг, тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй хандах;
- 2.3.6.өөрийн буруутай үйл ажиллагааны хариуцлагыг шударгаар хүлээж, дахин давтахгүй, шаардлагатай тохиолдолд албан тушаалаасаа татгалзах ёс зүйтэй байх;
- 2.3.7.энэ дүрмийг зөрчсөн аливаа үйлдэлтэй үл эвлэрч, өөрийн болон бусдын алдаа, дутагдлыг илрүүлэн засч, ажиллахыг эрмэлзэх.

2.4.Ажилтны ёс зүйн хэм хэмжээ:

- 2.4.1.хууль тогтоомж, компанийн дүрэм, дотоод журмыг чанд баримталж, компанийн нэр хүндийг дээдлэх;

ТӨСӨЛ 2022.02.21

2.4.2.өөрийн мэдлэг, чадварыг байнга хөгжүүлж, үүрэгт ажлаа мэргэжлийн түвшинд үнэнч шударгаар хариуцлагатай гүйцэтгэж, ажилдаа хүндэтгэлтэй хандах.

2.5.Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан ашиг сонирхлын зөрчил, авлигаас сэргийлэх чиглэлээр дараах үйлдэл, эс үйлдэл гаргахыг хориглоно;

2.5.1.чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөртөө болон нэгдмэл сонирхолтой этгээдэд шууд болон шууд бусаар давуу тал олгох;

2.5.2.оролцогч этгээдтэй үгсэн тохирох, амлалт өгөх, хахууль авах, бэлэг, урамшуулал, шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, хууль бус бусад хангамж эдлэх;

2.5.3.ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх, сонирхлын зөрчил үүсгэх буюу болзошгүй ажлыг гадуур давхар эрхлэх;

2.5.4.хувь хүн, албан байгууллагаас зөвшөөрөгдсөн буюу мөнгөн хэлбэрийн бус, үүрэг хариуцлага, хүлээлт, найдлага шаардаагүй, нээлттэй, ердийн байдлаар хаяглагдсанаас бусад бэлэг хүлээн авах.

### ГУРАВ.ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

3.1.ТУЗ-өөс комплайнсын хяналтын нэгжийн жил бүрийн төсвийг батлан хүний нөөцийг томилж, шууд харьцана. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь комплайнсын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээдэд шаардлагатай туслалцаа, дэмжлэгийг үзүүлж, бие даасан хараат бус байдлыг хангана.

3.2.Компанийн ажилтан ёс зүйн дүрэм зөрчсөн, зөрчиж болзошгүй алива үйлдэл, эс үйлдлийг Комплайнсын нэгж/ажилтанд нэн даруй мэдэгдэж, шүтэл үлээгч байна.

3.3.Ажилтны ёс зүйн дүрэм зөрчсөн мэдээллийг комплайнсын нэгж/ажилтан хянаад холбогдох саналыг гүйцэтгэх удирдлагад шилжүүлж, шийдвэрлүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-д хүргүүлнэ.

3.4.Комплайнсын нэгж/ажилтны дүгнэлтийг үндэслэн гаргасан зөрчил, хохирлын хэмжээг харгалзан гүйцэтгэх захирлын тушаалаар ажилтанд Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл оногдуулна.

3.5.Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн гишүүнтэй холбоотой ёс зүйн зөрчлийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны гаргасан дүгнэлтийг үндэслэн ТУЗ-ийн хурлын тогтоолоор холбогдох шийтгэлийг оногдуулна. Шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

3.6.Ёс зүйн дүрэм зөрчиж, зөрчил гаргасан нь гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэх эрхтэй.

3.7.Ёс зүйн дүрэм зөрчиж, зөрчил гаргаж, шийтгэл хүлээсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд зөрчилтэйд тооцно.

*Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ний .... тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хавсралт 3*

## ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОДЛОГЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү баримт бичгээр компанийн цалин, урамшууллын зарчим, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлно.

### ХОЁР. ҮНДСЭН ЧИГЛЭЛ

2.1.Цалин, урамшууллын талаар компанийн хэмжээнд баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

2.1.1.ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, урамшуулал олгох;

2.1.2.цалин, урамшууллын хуваарилалтад аливаа ялгаварлал, гадуурхал, тэгш бус байдлыг гаргахгүй байх;

2.1.3.цалин, урамшууллыг ур чадвар болон ажлын үнэлгээ, үр дүнд суурилж тогтоох;

2.1.4.хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн өсөлтийн зохистой харьцаа болон инфляцийн түвшинтэй уялдуулж бодит цалингийн өсөлтийг хангах;

ТӨСӨЛ 2022.02.21

2.1.5.Монгол Улсын нэгдсэн орсон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, Зохистой хөдөлмөрийн үзэл баримтлалын дагуу ажиллагсдын цалин, урамшууллыг шударга хуваарилах, хөдөлмөрчдийн эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр болон хамтын гэрээ байгуулах эрхийг хүлээн зөвшөөрөх.

2.2.ТУЗ-ийн дэргэдэх цалин, урамшууллын хороо /цаашид "Хороо" гэх/ нь компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнуудад олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах, холбогдох хууль тогтоомж болон ТУЗ-өөс тодорхойлсон бусад асуудлын хүрээнд дараах хэлбэрээр, зохистой хэмжээг тогтоон олгоно:

2.2.1.тогтмол цалин;

2.2.2.хуралд оролцсон цалин;

2.2.3.компанийн жилийн үр дүнг үндэслэн нэг удаа олгох урамшуулалт цалин;

2.2.4.мэргэжлийн, өндөр ур чадвартай гүйцэтгэх удирдлагыг тогтвор суурьшилтай ажиллуулах, идэвхжүүлэхэд хангалттай хэмжээний цалин, урамшуулал;

2.2.5.компанийн үйл ажиллагааны чиглэл болон бусад нөхцөл байдлаас шалтгаалсан бусад хэлбэрийн урамшуулал.

2.3.Хороо нь эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг ТУЗ-өөр батлуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих, холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргана.

2.4.Хороо нь компанийн ажилтны цалин, урамшуулалтай холбоотой дотоод дүрэм, журам, системийн үр дүнг үнэлж, холбогдох хууль тогтоомжид нийцэж буй байдалд хяналт тавих, компанийн цалингийн бодлого, түвшин, бүтэц, цалин тогтоох журамд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ-д тайлагнаж, ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлнэ.

2.5.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарна.

-000-

*Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ний ....  
тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ийн хавсралт 4*

## **ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэхүү баримт бичгээр компанийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааны бодлогыг тодорхойлно.

1.2.Бодлогын баримт бичгийн зорилго нь компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, удирдах албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангахын тулд эрх бүхий албан тушаалтны залгамж халааг тодорхойлоход оршино.

### **ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2.1.ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо /цаашид "Хороо" гэх/ нь залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулж ТУЗ-д танилцуулна.

ТӨСӨЛ 2022.02.21

2.2.Хороо нь эрх бүхий албан тушаалд дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх замаар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.

2.3.Хороо нь компанийн эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно. Хороо нь компанийн хүний нөөц болон гаднаас эрх бүхий албан тушаалд тохирох нэр дэвшигчийг тодорхойлж, санал болгоно.

2.4.Хорооноос эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр улираан нэр дэвшүүлэх, эсхүл чөлөөлөх саналыг гаргана.

2.5.Өндөр насны тэтгэвэрт гарах болон таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо болон гүйцэтгэх удирдлага нь жил бүрийн давтамжтайгаар судалгаа хийнэ.

#### ГУРАВ. БУСАД

3.1.Энэ баримт бичгийн хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.

-000-

*Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ний ....  
тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хавсралт 5*

### НОГДОЛ АШГИЙН БОДЛОГЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

#### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэ баримт бичгээр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах бодлогыг тодорхойлно.

#### ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1.Компани татвар төлсний дараах цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилахдаа дараахь зарчмыг баримтална:

2.1.1.ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

2.1.2.ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

2.1.3.компани эргүүлэн авах үүрэг хүлээсэн үнэт цаасаа бүрэн авсан байх.

ТӨСӨЛ 2022.02.21

2.2.ТУЗ нь компанийн хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд уг шийдвэрийг хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор гаргах ба энэ баримт бичгийн 2.1-т заасан нөхцөл хангагдсан байна.

2.3.Ногдол ашиг тараах хэлбэр ба хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын баталсан журам, зааврыг зөвлөмжийг дагаж мөрдөнө.

2.4.Ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон тооцооллыг ТУЗ гаргана. Тооцооллыг гүйцэтгэх удирдлагаас санал болгож болно.

2.5.Компани нь ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хууль, холбогдох журамд заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.

2.6.ТУЗ-өөс ногдол ашгийг тараах өдрийг тогтоохдоо компанийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боломжит хугацааг харгалзана.

2.7.Компани нь өөрийн цахим хуудсанд ногдол ашгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг байршуулна.

2.8.Ногдол ашиг тараасны дараа үлдэх ашгаас нийгмийн хариуцлага, соёлын арга хэмжээний санг ТУЗ-ийн шийдвэрээр байгуулж болно. Сан байгуулах, түүний хөрөнгийг захиран зарцуулах журмыг гүйцэтгэх удирдлага боловсруулж, ТУЗ-ийн тогтоолоор батална.

2.9.Компани нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хугацаанд нь тараагаагүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх ба компанид учирсан хохирлыг гүйцэтгэх захирал хариуцна.

-ооо-

*Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ний ....  
тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хавсралт 6*

## **ДОТООД АУДИТЫН ЗААВРЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэхүү баримт бичгээр компани өөрийн дотоод аудитын тогтолцоог боловсронгуй болгох, дотоод аудитын нэгжийн ажиллах зарчим, аудит хийх чиглэл, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлно.

### **ХОЁР. ЗОРИЛГО**

2.1.Дотоод аудит нь компанийн үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхээр хараат бус, бие даасан, бодитойгоор баталгаа өгөх ба зөвлөх үйл ажиллагаа байна.

2.2.Компани дотоод аудитын бодлогоо тодорхойлохдоо үйл ажиллагаандаа зайлшгүй анхаарах асуудлыг тусган, компанийн онцлог, тухайн үеийн нөхцөл байдал, хэтийн төлөвт тулгуурлана.

### **ГУРАВ. ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

ТӨСӨЛ 2022.02.21

3.1.Компани нь дотоод аудитыг хэрэгжүүлэх дотоод аудитын нэгжтэй байна. Дотоод аудитын нэгж нь компанийн бүхий л үйл ажиллагааны түвшинд эрсдэлд суурилсан дотоод аудитын үйл ажиллагааг явуулах бөгөөд дотоод аудит нь дараах чиглэлтэй байна:

3.1.1.компанийн засаглалын үйл явцыг үнэлж, сайжруулах зөвлөмж өгөх;

3.1.2.эрсдэлийн удирдлагын үйл явцын үр нөлөөтэй ба үр ашигтай байдлыг үнэлэх, сайжруулах;

3.1.3.дотоод хяналтын системийн үр нөлөөтэй ба үр ашигтай байдалд үнэлгээ хийх, тэдгээрийн байнгын сайжруулалтад дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах;

3.1.4.компанийн санхүүгийн үйл ажиллагаа нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, мөрдөж буй заавар, журмын дагуу үнэн зөв тайлагнаж буй эсэхэд баталгаажуулалт өгөх.

3.2.Дотоод аудитын нэгж нь дараах зарчмуудыг баримталж ажиллана. Үүнд:

3.2.1.шударга байх;

3.2.2.мэргэжлийн мэдлэг, ур чадвартай байх;

3.2.3.хараат бус, бие даасан байх;

3.2.4.компанийг стратеги зорилго, зорилтдоо амжилттай хүрэхэд дэмжлэг үзүүлж, учирч болох эрсдэлийг тодорхойлох;

3.2.5.хүний нөөц, төсөв санхүүг оновчтой төлөвлөх;

3.2.6.аудитын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулж байх;

3.2.7.аудитад хамрагдаж буй газар, нэгжүүдтэй үр дүнтэй харилцах;

3.2.8.аудитын эцсийн дүгнэлтэд эрсдэлд суурилсан баталгаажуулалт өгөх;

3.2.9.байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар хийж буй өөрчлөлт, шинэчлэлийг дэмжих.

3.3.Аудитын хорооноос санал болгосноор компанийн дотоод аудитын нэгжийн дарга, ажилтнуудыг ТУЗ-өөс томилно.

3.4.ТУЗ нь дотоод аудитын үйл ажиллагааг дараах байдлаар хариуцаж ажиллана:

3.4.1.дотоод аудитын бодлогыг тодорхойлох, батлах, түүнийг өөрчлөх;

3.4.2.эрсдэлд суурилсан дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлийг хянах;

3.4.3.дотоод аудитын нэгжийн орон тоо, төсөв, удирдлага, ажилтнуудын цалин, урамшууллыг тогтоох;

3.4.4.дотоод аудитын нэгжийн ажиллах журам, дүрэм, гарын авлагыг батлах;

3.4.5.дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаа нь компанийн үйл ажиллагаанд эергээр нөлөөлж, туслалцаа дэмжлэг үзүүлж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.4.6.дотоод аудитын тайлан, дүгнэлтэй тухай бүр танилцаж, аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу авах арга хэмжээнүүдийн талаар шийдвэр гаргах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.4.7.дотоод аудитын тогтолцоо, үйл ажиллагааг Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартаар тогтоосон хэлбэрээр зохион байгуулж, хэрэгжүүлж чадаагүйгээс компанид ноцтой эрсдэл учирсан болон учирч болзошгүй нөхцөл байдал үүссэн бол дотоод аудиторт хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авах.

3.5.Гүйцэтгэх удирдлага, ажилтнууд нь дотоод аудитын нэгжтэй дараах байдлаар хамтран ажиллана:

3.5.1.дотоод аудитын нэгжийг хараат бусаар ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангаж, ажилд нь хүндрэл учруулахгүй байх;

3.5.2.дотоод аудитын удирдамжид зааснаар дотоод аудиторын шаардсан мэдээ, материал, лавлагаа, тайлбарыг аудит хийлгэж байгаа нэгжийн удирдлага, ажилтнууд холбогдох дүрэм, зааврын дагуу хугацаанд нь гаргаж өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд ярилцлага, санал асуулгад оролцох;

3.5.3.дотоод аудитаар гарсан зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах.

3.6.Дотоод аудитын нэгж нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

ТӨСӨЛ 2022.02.21

- 3.6.1. дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө, ажиллах дүрэм, журам, гарын авлагыг боловсруулж, ТУЗ-өөр батлуулан, хэрэгжүүлэх;
- 3.6.2. хууль тогтоомж, бодлогын баримт, дүрэм, журам, дотоод аудитын олон улсын стандартын дагуу дотоод аудитыг гүйцэтгэх;
- 3.6.3. дотоод аудитын тайланг гүйцэтгэх удирдлагад танилцуулж, баталгаажуулсны дараагаар Аудитын хороогоор хэлэлцүүлэх;
- 3.6.4. эрсдэлд суурилсан дотоод аудитыг гүйцэтгэж, компанийн өндөр эрсдэлтэй хэсгүүдэд ажиллах;
- 3.6.5. дотоод аудитыг мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу явуулах ба компанийн нэгжийн ажилтнуудаас ярилцлага, асуулга, лавлагаа, тодруулга авч, ажлын баримтад тулгуурлан үнэн зөв, бодитой үнэлгээ, дүгнэлт гаргах;
- 3.6.6. дотоод аудитын нэгжийн удирдлага нь дотоод аудитыг тогтоосон хугацаанд чанартай, үр дүнтэй байхаар ажлын хэсгийг зохион байгуулахын зэрэгцээ ажлын явц, гүйцэтгэлийн талаар болон шаардлагатай гэж үзсэн тохиолдолд аудитын удирдамжид өөрчлөлт оруулах саналаа ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэх;
- 3.6.7. дотоод аудитыг хийхдээ шалгуулагчийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүйгээр явуулах.

3.7. Дотоод аудит нь дараахь үйл ажиллагааны бүх шатанд хэрэгжинэ. Үүнд:

- 3.7.1. гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа;
- 3.7.2. дотоод хяналт;
- 3.7.3. эрсдэлийн удирдлага;
- 3.7.4. компанийн бусад нэгжийн удирдлагын үйл ажиллагаа;
- 3.7.5. компанийн ажилтны үйл ажиллагаа.

#### ДӨРӨВ. БУСАД

4.1. Дотоод аудитын мэргэжил, практикийн олон улсын өөрчлөлт, хөндлөнгийн аудитын дүгнэлт, ТУЗ, түүний дэргэдэх Аудитын хорооны саналд үндэслэн дотоод аудитын бодлогод өөрчлөлт орж болно.

-000-

*Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ний ....  
тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хавсралт 7*

### ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗААВРЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

#### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү баримт бичгийг компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, хянахад баримталж ажиллана.

#### ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. ТУЗ нь байгууллагын үйл ажиллагааны бүхий л чиглэлийг эрсдэлийн удирдлагаар хангаж, нэгдсэн үйл ажиллагааг хариуцан, дотооддоо мөрдөх зааврыг байгууллагын бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцүүлэн батална.

2.2. Заавраар байгууллагын зорилго, зорилтод нөлөөлөх эрсдэл, ирээдүйд тохиолдох магадлал ба нөлөөллийг үнэлснээр эрсдэлд хариу өгөх арга хэмжээ, түүнийг үнэлэх үйл явцад мониторинг хийх зэрэг эрсдэлийн удирдлагын хүрээг тодорхойлно.

ТӨСӨЛ 2022.02.21

2.3.ТУЗ нь зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо, байхгүй бол Аудитын хороо нь байгууллагын эрсдэлийн удирдлага, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

2.4.Энэхүү баримт бичгийг цаг үедээ тохируулан тухай бүр шинэчлэн батална.

### ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

3.1.эрсдэлийг тодорхойлох: тулгарч буй хүндрэлийг шийдвэрлэх болон бизнесийн цар хүрээг нэмэгдүүлэх, гуравдагч талын харилцаа, зах зээлээс хамаарсан, эсхүл зохицуулалтын орчинд гарсан өөрчлөлт зэргээс үүсэх магадлалтай эрсдэлийг байгууллагын бүхий л түвшинд тодорхойлно. Ингэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзана:

3.1.1.эрсдэлийн шинж чанар /nature of the risk/ - хаана, хэзээ, ямар үйл явдал;

3.1.2.эрсдэлийн эх үүсвэр /source of the risk/ - ямар хүчин зүйлс, хүн, үйл ажиллагаа;

3.1.3.эрсдэлийн шалтгаан /cause of the risk/ - шууд болон шууд бус шалтгаан;

3.1.4.эрсдэлийн нөлөө /effect of the risk/ - үүсэх үр дагавар, хамгийн сөрөг нөлөө.

3.2.эрсдэлийг үнэлэх: эрсдэлийн нөлөөллийн хүчин зүйлсийг ялгаж харах зорилгоор ач холбогдлын түвшингээр нь ангилж, үнэлэх ба эрсдэлийг хэмжихэд ашиглаж буй арга зөв эсэхийг тогтмол шалгана. Эрсдэлийг чанарын болон тоон хэрэгслүүдийг ашиглан үнэлнэ.

3.3.эрсдэлийг удирдах: эрсдэлийн үнэлгээний үр дүнд эрсдэлд үзүүлэх хариу арга хэмжээг тодорхойлох ба эрсдэлийн удирдлагын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

### ДӨРӨВ. БУСАД

4.1.Гүйцэтгэх удирдлага нь эрсдэлийн удирдлагын зааврын хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор төлөвлөгөө боловсруулж, байгууллагын эрсдэлийг тодорхойлон үнэлж, удирдах үйл ажиллагааг явуулна.

4.2.Гүйцэтгэх удирдлагын дэргэд байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын нэгж, эсхүл ажилтан байх бөгөөд бусад гүйцэтгэх шатны удирдлагуудтай байнгын харилцан холбоотой ажиллана.

4.3.Гүйцэтгэх удирдлага эрсдэлийн удирдлагын нэгж эсхүл ажилтнаар дамжуулан эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө тухайн байгууллагад нийцсэн үр дүнтэй эсэх, төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

*Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ний ....  
тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хавсралт 8*

## ДОТООД ХЯНАЛТЫН ЗААВРЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү баримт бичгийг гүйцэтгэх удирдлага нь өөрийн дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ баримтлах зарчим, дотоод хяналтын үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлоход баримтална.

1.2.Дотоод хяналт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.

1.3.“дотоод хяналт” гэж хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилт, төсөв санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдлыг хангахад чиглэсэн нягтлан шалгах үйл ажиллагааг хэлнэ.

1.4.Дотоод хяналт нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, арга зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ.

## ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1.ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын боловсруулсан дотоод хяналтын заавар, төлөвлөгөөг хэлэлцэн баталж, өөрийн дэргэдэх Аудитын хороо, дотоод аудитын нэгжээр дамжуулан заавар, төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавина.

2.2.Гүйцэтгэх удирдлага нь дотоод хяналтын төлөвлөгөөний гүйцэтгэлийг дараах байдлаар гаргана:

- 2.2.1.дотоод хяналтын заавар, төлөвлөгөөгөө боловсруулахдаа дотоод аудитын нэгжийн санал, дүгнэлтийг тусгасан байх;
- 2.2.2.дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж, өдөр тутмын удирдлагаар хангах;
- 2.2.3.дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэхдээ дотоод хяналтын нэгж байгуулах, компанийн нэгжүүд нь өөрийн үйл ажиллагаандаа дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах, эсхүл ажилтан томилон ажиллуулах;
- 2.2.4.дотоод хяналтын нэгж, эсхүл дотоод хяналтын ажилтны ажиллах дүрэм, журам, зарчмыг батлах;
- 2.2.5.дотоод хяналтын нэгж, эсхүл ажилтны ажлыг дүгнэх;
- 2.2.6.дотоод хяналтын нэгж, эсхүл ажилтан бие даан, хараат бусаар хяналтаа хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөлөөр хангах;
- 2.2.7.шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мэргэжлийн зөвлөх ажиллуулах.

2.3.Дотоод хяналтын нэгж, эсхүл ажилтан нь зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, салбар, нэгжээс хараат бус байх ба дараах шаардлагыг хангаж ажиллана:

- 2.3.1.компанийн үйл ажиллагааны чиглэлээр мэдлэг, туршлагатай, шударга хяналтыг хэрэгжүүлэх мэргэжлийн ёс зүйтэй байх;
- 2.3.2.компанийн үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог, зохион байгуулалтын бүтэц, харьяа нэгж, салбарын тоог харгалзан тухайн жилд хийх хяналтын ажлын төлөвлөгөөг боловсруулан гүйцэтгэх удирдлагаар батлуулан, мөрдөж ажиллах;
- 2.3.3.дотоод хяналтын ажлын дүн, авсан арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар тухай бүр гүйцэтгэх удирдлагад тайлагнах;
- 2.3.4.гүйцэтгэх удирдлагын баталсан удирдамжийн дагуу дотоод хяналтыг гүйцэтгэх.

2.4.Дотоод хяналтын нэгж, эсхүл ажилтан нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй байна:

- 2.4.1.дотоод хяналтыг хэрэгжүүлэх батлагдсан удирдамжийн дагуу холбогдох баримт бичиг, бүртгэлийг шалгах;
- 2.4.2.компанийн үйл ажиллагаа, компанийн дотоод дүрэм, журам нь холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянаж, нийцүүлэн ажиллах явцыг дүгнэх;
- 2.4.3.дотоод хяналтыг явуулахдаа компанийн ажилтнууд, салбар, нэгжийн удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай тайлан мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах;
- 2.4.4.илэрсэн зөрчил, дутагдал, эрсдэлийн талаарх мэдээллийг бүртгэн, шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар гүйцэтгэх удирдлагад санал тавьж, шийдвэрлүүлэх;
- 2.4.5.шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар гүйцэтгэх удирдлагад санал тавьж, шийдвэрлүүлэх;
- 2.4.6.хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

ТӨСӨЛ 2022.02.21

2.4.7.холбогдох дүрэм, журам, заавар, стандартыг боловсронгуй болгох талаар судалгаа хийж, дүгнэлт гаргах;

2.4.8.дотоод хяналтын үр нөлөө болон мэдлэг, ур чадвараа сайжруулах зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, сургалтад хамрагдах.

### ГУРАВ. БУСАД

3.1.Дотоод хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, компанийн үйл ажиллагааны дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна.

3.2.Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол хууль, хяналтын байгууллагад шилжүүлнэ.

-оОо-

*Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ний .... тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хавсралт 9*

## **КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫН ЗААВРЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэхүү баримт бичгээр комплайнсын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд комплайнсын нэгж/ажилтан нь холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг судалж, дотооддоо хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлно.

1.2.Энэхүү баримт бичгээр комплайнсын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд комплайнсын нэгж/ажилтан нь компанийн дотоодод мөрдөгдөх дүрэм, журам, зааварболон үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан шаардлага стандартад нийцүүлж, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлно.

## ХОЁР. ЗОРИЛГО

### 2.1.Комплайнсын хяналтын зааврын зорилго нь:

- 2.1.1.эрсдэлийн удирдлагыг бий болгох замаар компанийн засаглалыг сайжруулах;
- 2.1.2.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр, дүрэм, журам боловсруулах, хэрэгжүүлэх;
- 2.1.3.байгууллагын комплайнсын соёлыг бүрдүүлэх, төлөвшүүлэх, сургалт зохион байгуулах;
- 2.1.4.зөрчлийн талаар мэдээлэх “шүгэл үлээх” ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино.

## ГУРАВ. ҮНДСЭН ЗАРЧИМ

### 3.1.Комплайнсын хяналтын зааврыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

#### 3.1.1.Хараат бус, бие даасан байх:

- комплайнсын хяналтын үйл ажиллагаа албан ёсны бие даасан байна;
- комплайнсын нэгж/ажилтантай байна;
- сонирхлын зөрчлөөс ангид байна;
- комплайнсыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөвтэй байна.

#### 3.1.2 Ил тод, нээлттэй байх:

- комплайнсын нэгж/ажилтан холбогдох дотоод нэгжээс мэдээлэл гаргуулах, мэдээлэх;
- комплайнсын нэгж/ажилтны байгууллагын бусад нэгжүүд болон дотоод хяналтын нэгжтэй хамтран ажиллах.

## ДӨРӨВ. КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫН ЗААВРЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

### 4.1.Комплайнсын хяналтын зааврыг хэрэгжүүлэх үндсэн тогтолцоог/чиглэлийг дараах түвшинд тодорхойлно:

#### 4.1.1.ТУЗ-ийн чиг үүрэг:

- 4.1.1.1.бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журам, зааврыг батална;
- 4.1.1.2.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр байгууллагын эрсдэлийн төвшин, онцлогт нийцсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина;
- 4.1.1.3.комплайнсыг хэрэгжүүлэх ажилд шаардлагатай төсөв, хөрөнгийг батална;
- 4.1.1.4.комплайнсын ажилтанг томилон түүнтэй шууд харьцаж, тайлан мэдээг хүлээн авч танилцана.

#### 4.1.2.Гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг:

- 4.1.2.1.ТУЗ-ийн баталсан хөтөлбөр, бодлогын баримт бичиг, зааврыг хэрэгжүүлнэ;
- 4.1.2.2.комплайнсын хяналтын зааврыг хэрэгжүүлэх хүрээнд өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, чиглүүлнэ;
- 4.1.2.3.байгууллагын эрсдэлийг олж илрүүлэх, удирдах, хянах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;
- 4.1.2.4.дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр тухайн байгууллагад нийцэж буй эсэх, мөн үр дүнтэй эсэхэд нь хяналт тавьж ажиллана.

#### 4.1.3.Компанийн ажилтны чиг үүрэг:

- 4.1.3.1.хууль тогтоомж, дотоод хөтөлбөр, бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг мөрдөнө;
- 4.1.3.2.мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө;
- 4.1.3.3.комплайнсын хяналт шалгалтад шаардлагатай туслалцаа үзүүлж, хамтран ажиллана.

#### 4.1.4.Байгууллагын үйл ажиллагааны онцлог, нөөцөд нийцүүлэн комплайнсын нэгж/ажилтантай байна. Комплайнсын чиг үүргийг өөр ажил гүйцэтгэдэг ажилтанд давхар хариуцуулж болох бөгөөд комплайнсын нэгж/ажилтан нь дараах чиг үүрэгтэй байна:

- 4.4.1.1.хууль тогтоомж, эрх зүйн актууд болон байгууллагын дотоод дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хянах, хангуулах;

ТӨСӨЛ 2022.02.21

4.4.1.2.байгууллагын онцлогт тохирсон хөтөлбөр, бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журам, заавар боловсруулах;

4.4.1.3.байгууллагын ажилтан, удирдлагад зориулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх;

4.4.1.4.комплайнсын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэн ТУЗ-д шууд тайлагнах, удирдлагыг мэдээллээр хангаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж гаргах;

4.4.1.5.зохицуулагч болон гадны байгууллагатай харилцахдаа комплайнсын чиглэлээр байгууллагыг төлөөлөх, зохицуулагч байгууллагаас шаардсан мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөх;

4.4.1.6.байгууллагад комплайнсын соёлыг бүрдүүлэх, төлөвшүүлэх;

4.4.1.7.зөрчлийн талаар мэдээлэх “шүгэл үлээх” ажиллагааг хэрэгжүүлэх.

4.2.Комплайнсын ажилтан өөрийн шууд удирдлагад үйл ажиллагаагаа тайлагнах нөхцөлүүдийг дотоод дүрэм, журамд тусгана.

4.3.Комплайнсын нэгж/ажилтан нь санаачлагаараа байгууллагын бүх нэгжийн албан хаагчидтай хамтран ажиллаж, комплайнсын чиглэлээр шаардлагатай гэж үзсэн мэдээллийг авах эрхтэй.

4.4.Комплайнсын хяналтын үйл ажиллагааны чухал хэсэг бол мэргэшсэн, туршлагатай хүний нөөц бөгөөд комплайнсын ажилтнаар хууль тогтоомж, эрх зүйн акт, тэдгээрийн үр нөлөө, ач холбогдлын талаар зохих мэдлэгтэй хүнийг томилно.

4.5.Комплайнсын нэгж/ажилтан нь зохицуулагч байгууллагатай дараахь байдлаар хамтран ажиллана:

4.5.1.зохицуулагч болон хяналтын байгууллагаас шаардсан баримт, тайлан мэдээг хугацаанд нь бэлтгэж, хүргүүлэх;

4.5.2.маргаантай асуудлаар хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах.

#### ТАВ. ШҮГЭЛ ҮЛЭЭХ АЖИЛЛАГАА

5.1.Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь ёс зүйн дүрмийг зөрчсөн, эсхүл зөрчигдөж байгаа, зөрчигдөж болзошгүй талаар мэдсэн, ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэх, албан тушаалын давуу байдлыг ашиглах, хайнга хандах, авлига, хээл хахуультай холбогдох зэрэг хууль бус үйлдэлд шүгэл үлээгч байна.

5.2.Комплайнсын нэгж/ажилтан нь шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авч, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

5.3.Комплайнсын нэгж/ажилтан зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч, хянах явцад мэдээлэгчийн нууцлалыг чандлан хадгална.

5.4.Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь комплайнсын нэгж/ажилтанд хандан ёс зүйн зөрчлийн талаар заавар, зөвлөгөө, мэдээлэл авах эрхтэй.

5.5.Комплайнсын нэгж/ажилтан нь мэдээллийг бичгээр, цахим шуудан, утас, факс, цахим хуудсыг ашиглан хүлээн авч болох бөгөөд хариуг мөн энэ хэлбэрээр хүргүүлнэ.

5.6.Комплайнсын нэгж/ажилтан нь энэ бодлогын баримт бичигт хяналт тавьж, мөрдүүлэх ажлын хүрээнд зөрчлийн мэдээлэлд үндэслэн холбогдох этгээдтэй уулзах, тайлбар нотолгоог гаргуулан авч, хянан, сахилгын шийтгэл ногдуулах эсэх талаар дүгнэлт гаргана.

#### ЗУРГАА. ТАЙЛАГНАЛ

6.1.Комплайнсын хяналтын бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

6.1.1.авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх;

6.1.2.мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, тэмцэх;

ТӨСӨЛ 2022.02.21

- 6.1.3.мэдээллийн нууцлал, аюулгүй байдал;
- 6.1.4.бэлэг өгөх, хүлээн авах зохицуулалт;
- 6.1.5.зөрчлийн талаар мэдээлэх “шүгэл үлээх”;
- 6.1.6.шударга өрсөлдөөнийг хангах;
- 6.1.7.нийгмийн хариуцлага.

6.2.Комплайнсын нэгж/ажилтны тайланд дараахь асуудлыг тусгасан байна:

- 6.2.1.комплайнсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл;
- 6.2.2.сургалт, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилт;
- 6.2.3.байгууллагын нэгж болон ажилтнууд комплайнсын хөтөлбөрийн дагуу хэрхэн ажиллаж байгаа талаарх үнэлгээ;
- 6.2.4.ТУЗ, гүйцэтгэх удирдлага, нэгж, ажилтантай холбоотой гарсан комплайнсын аливаа асуудал болон авсан арга хэмжээ;
- 6.2.5.комплайнсын хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөнд өгөх санал дүгнэлт.

6.3.Комплайнсын ажилтны эрх, үүрэг хариуцлага, ажлын биелэлтийг хэнд, ямар давтамж болон хэлбэрээр мэдээлэх, тайлагнах талаар комплайнсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаж, баталгаажуулна.

6.4.Комплайнсын ажилтан үйл ажиллагаагаа шууд холбогдох газар нэгж, гүйцэтгэх удирдлагад тайлагнана. Мөн комплайнсын ажилтны бие даасан, хараат бус байдлыг хангахын тулд ТУЗ-д ажлаа тайлагнана.

#### ДОЛОО. БУСАД

7.1.Энэхүү баримт бичгийн хэрэгжилтэнд гүйцэтгэх удирдлага, комплайнсын нэгж/ажилтан хяналт тавьж ажиллах ба ТУЗ нь энэхүү зааврын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.

-o0o-

*Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ний .... тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хавсралт 10*

### **“.....” ХК/ХХК-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

#### **1. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

1.1.Энэхүү үнэлгээний зорилго нь Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг үнэлэх, хувьцаат компанийн засаглалын түвшин болоод тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо”)–ноос гэх заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг ахиулахад оршино.

1.2.Зайны үнэлгээг хувьцаат компанийн эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэнэ.

1.3.Тухайн хувьцаат компанийн зайны үнэлгээний дүн нь олон нийтэд нээлттэй бус мэдээлэл бөгөөд Хорооны зүгээс компанийн засаглалын өнөөгийн нөхцөл байдал, холбогдох дүрэм, журмыг

ТӨСӨЛ 2022.02.21

боловсронгуй болгоход дүн шинжилгээ хийх зорилгоор нэгдсэн судалгаанд тухайн компанийн нэрийг дурдахгүйгээр ашиглана.

1.4.Хорооны зүгээс компанийн зайны үнэлгээнд үндэслэн тухайлсан зөвлөмж, заавар, аргачлалыг боловсруулан буцааж хүргүүлэх ба тэдгээрийн биелэлтээр зайны үнэлгээний ахиц дэвшлийг тодорхойлно.

1.5.Тухайн зайны үнэлгээний дүн нь аливаа хариуцлага тооцох үндэслэл болохгүй боловч зайны үнэлгээг хийж, Хороонд ирүүлээгүй тохиолдолд тухайн компанийн засаглалын үнэлгээ хангалтгүйд тооцогдож, газар дээрх хяналт шалгалтад хамрагдах үндэслэл болно.

## 2.ҮНЭЛГЭЭНИЙ ЗАГВАР

Компанийн засаглалын үнэлгээний загвар нь нийт 70 асуулт бүхий дараах бүтэцтэй байна:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлгээний оноо	Үнэлгээний хувь
1	Хувьцаа эзэмшигчийн эрх	26		
2	Төлөөлөн удирдах зөвлөл, түүний хороод	38		
3	Гүйцэтгэх удирдлага	10		
4	Мэдээллийн ил тод, нээлттэй байдал	40		
5	Хяналтын тогтолцоо	26		
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>140</b>		

## 3.ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

3.1.Асуулга тус бүрийн хувьд бүрэн биелсэн 2, хэсэгчлэн биелсэн 1, биелээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба бүрэн болон хэсэгчлэн биелсэн талаар холбогдох тайлбарыг оруулна.

3.2.Баримт бичгийг баталж, гүйцэтгэлийн тайланг гаргасан бол 2 оноо, хэрэв баримт бичгийг баталсан боловч тайлан гаргаагүй бол 1 оноогоор үнэлнэ.

3.3.Тайлбар хэсэгт бодлогын баримт бичиг, дүрэм, журмыг баталсан болон гүйцэтгэлийн тайланг хэлэлцсэн огноо, дугаарыг бичнэ.

3.4.Нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын компанийн засаглалыг дараах байдлаар үнэлнэ:

3.4.1.үнэлгээний нэгдсэн дүн нь авбал зохих нийт онооны 75 хувь болон түүнээс дээш байвал сайн засаглалтай буюу удирдлагын үйл ажиллагаа хэвийн;

3.4.2.үнэлгээ 50-74 хувь байвал дунд засаглалтай буюу удирдлагын үйл ажиллагаанд асуудал үүсч болзошгүй;

3.4.3.үнэлгээ 25-49 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу зайны болон газар дээрх хяналт шалгалтаар зохицуулалтын арга хэмжээ авах нөхцөл бүрдсэн;

3.4.4.үнэлгээ 24 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу удирдлагын үйл ажиллагаанд бүтцийн өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай.

## 4.ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГА:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ						
№	Гарчиг	Асуулт	Компанийн засаглалын кодексыг, Компанийн тухай хууль	Баталгаажуулах баримт бичиг	Үнэлгээ /тийм 2, хагас 1, үгүй 0/	Тайлбар /бүрэн, эсхүл хагас биелсэн тохиолдолд/
1		Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хэдэн сард хуралдуулсан бэ?	КтХ-ийн 59.4	ХЭХ-ын зар, тэмдэглэл		

ТӨСӨЛ 2022.02.21

2	Хувьцаа эзэмшигчийн эрх ашиг	Ээлжит хурал хуралдах үед хувьцаа эзэмшигчдэд Компанийн тухай хуулийн 65.6-д заасан баримт бичигтэй танилцах боломжийг бүрэн олгосон эсэх?	КтХ-ийн 65.6	ХЭХ-ын зар, материал		
3		Хувьцаа эзэмшигчдийн хурлыг амралтын өдрүүдэд /цахим хурлыг ажлын бус цагаар/ зохион байгуулсан эсэх?	КЗК-ын 4.3.1	ХЭХ-ын тэмдэглэл		
4		Хувьцаа эзэмшигчдийн хурлын хөтөлбөрт хувьцаа эзэмшигчид асуудал тус бүрээр асуулт тавьж, хариулт авах, хэлэлцүүлэг хийх хугацааг оруулсан эсэх?	КЗК-ын 4.3.5, 4.3.6	ХЭХ-ын хөтөлбөр		
5		Хэлэлцэх асуудлын жагсаалтад ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг оруулсан эсэх?	КтХ-ийн 62.1.7	ХЭХ-ын хөтөлбөр		
6		ТУЗ-өөс баталсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан эсэх?	КЗК-ын 2.1, 4.1.3, КтХ-ийн 92	ХЭХ-ын тэмдэглэл		
7		Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмыг баталж, мөрддөг эсэх?	КЗК-ын 4.3.5	ХЭХ хуралдуулах журам		
8		Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг хурал хуралдсанаас хойш ажлын нэг өдрийн дотор нийтэд мэдээлсэн эсэх?	ҮЦЗТХ-ийн 20.1.8, 56.1.6	Компани, МХБ-ийн цахим хуудас		
9		Хувьцаа эзэмшигч цахим хэрэгсэл ашиглан хувьцаа эзэмшигчдийн хуралд зайнаас оролцож, санал өгөх нөхцөлийг бүрдүүлсэн эсэх?	Компанийн засаглалын зарчмууд	Холбогдох журам ХЭХ-ын тэмдэглэл		
10		Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар болон материалыг хувьцаа эзэмшигчдийн цахим хаягаар хүргэсэн эсэх?	КЗК-ын 4.2.5	ХЭХ-ын зар ХЭХ-ын материал		
11		Ногдол ашиг	Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах журмыг баталсан эсэх?	КЗК-ын 2.2.2 а, б	Ногдол ашгийн бодлогын баримт бичиг,	
12	Ногдол ашиг хуваарилсан тохиолдолд хуваарилалтын тайлан, эсрэг тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнасан эсэх?		КтХ-ийн 46.6, 46.15	Хурлын тэмдэглэл		
13	Ногдол ашиг хуваарилсан тохиолдолд ногдол ашгийг “ҮЦТХТ” ТӨХХК-аар дамжуулахаар гэрээ байгуулсан эсэх?					
<b>НИЙТ ДҮН</b>						

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ДЭРГЭДЭХ ХОРООД**

№	Гарчиг	Асуулт	Компанийн засаглалын кодекс, Компанийн тухай хууль	Баталгаажуулах баримт бичиг	Үнэлгээ /туйм 2, хагас 1, үгүй 0/	Тайлбар /бүрэн ба хагас биелсэн тохиолдолд/
1	Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг	Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан журмыг баталж, мөрддөг эсэх?	КЗК-ын 5.1.4, КтХ-ийн 76.1.13	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам ТУЗ-ийн тайлан		
2		Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх чиглэлээр хөтөлбөр баталж, мөрддөг эсэх?	КтХ-ийн 76.1.13	Хөтөлбөр, эсхүл дотоод журам ТУЗ-ийн тайлан		
3		Гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг, хариуцлага, эрх хэмжээг зохицуулсан журам баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьсан эсэх?	КтХ-ийн 76.1.13 Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны ерөнхий заавар	Журам Гэрээ		
4		Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын тогтолцоог хурлын ирц, идэвх санаачлага, төлөвлөгөөний биелэлт зэрэгтэй нь уялдуулан зохицуулсан эсэх?		ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн тогтоол		

ТӨСӨЛ 2022.02.21

5		Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биеллэн оролцсон төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн ирц бүрэн эсэх?	Олон улсын сайн туршлага	ХЭХ-ын тэмдэглэл			
6		Компанийн эрх бүхий албан тушаалтны ёс зүйн асуудлыг дүрэмд тусгасан эсэх?	КЗК-ын 5.8.1	Компанийн ёс зүйн дүрэм			
7		Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журмыг баталж, тайланг хэлэлцдэг эсэх?	ТУЗ-ийн дэргэдэх хороодын үлгэрчилсэн журам	Нэр дэвшүүлэх, Цалин урамшуулал, Аудитын хорооны журам, тайлангууд ТУЗ-ийн хурлын тэмдэглэл			
8		Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон нарийн бичгийн дарга компанийн засаглалын чиглэлээр мэргэшсэн эсэх?	КтХ-ийн 75.8	Сургалтын гэрчилгээ			
9		Төлөөлөн удирдах зөвлөл нь жилийн ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангасан эсэх?	КтХ-ийн 80.1	Ажлын төлөвлөгөө Гүйцэтгэлийн тайлан			
10		Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн дүрэм болон хуульд зааснаас доошгүй удаа хуралдсан эсэх?	КтХ-ийн 80.1, Компанийн дүрэм	ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан			
11		Нэр дэвшүүлэх болон Цалин, урамшууллын хороод 6 сард нэгээс доошгүй удаа хуралдсан эсэх?	Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын, үлгэрчилсэн журам	ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх, цалин урамшууллын, хороодын үйл ажиллагааны тайлан			
12		Аудитын хороо нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдсан эсэх?	Аудитын хорооны үлгэрчилсэн журам	ТУЗ-ийн дэргэдэх хорооны үйл ажиллагааны тайлан			
13		Нэр дэвшүүлэх хороо нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургалт тогтмол зохион байгуулсан эсэх?	Нэр дэвшүүлэх, хорооны үлгэрчилсэн журам	Сургалтын хөтөлбөр материал Тайлан			
14	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод	Нэр дэвшүүлэх хороо нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн тус бүрийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, зөвлөмжийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан эсэх?	КТХ-ийн 81.5.4	Нэр дэвшүүлэх хорооны ажлын тайлан			
15		Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг Нэр дэвшүүлэх хороо дүгнэсэн эсэх?	КТХ-ийн 81.5.4	Нэр дэвшүүлэх хорооны үнэлэлт, дүгнэлт ТУЗ-ийн шийдвэр			
16		Нэр дэвшүүлэх хороо нь Залгамж халааны бодлогыг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж, мөрддөг эсэх?	КЗК-ын 5.6.7	Залгамж халааны бодлогын баримт бичиг Гүйцэтгэлийн тайлан ТУЗ-ийн дүгнэлт			
17		Аудитын хороо хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох саналыг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсан эсэх?	КтХ-ийн 81.4.3	Аудитын хорооны санал ТУЗ-ийн шийдвэр			
18		Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын ажиллах журмыг баталсан эсэх?	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны үлгэрчилсэн журам	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам		
19			Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга ажлаа төлөвлөж, тайлагнасан эсэх?	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлын төлөвлөгөө	Ажлын тайлан		
<b>НИЙТ ДҮН</b>							

ТӨСӨЛ 2022.02.21

№	Гарчиг	Асуулт	Компанийн засаглалын кодексыг, Компанийн тухай хууль	Баталгаажуулах баримт бичиг	Үнэлгээ /тийм 2, хагас 1, үгүй 0/	Тайлбар /бүрэн ба хагас биелсэн тохиолдолд/
1	Гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага	Гүйцэтгэх удирдлага нь холбогдох журмын дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө болон үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг ТУЗ-д тогтмол тайлагнадаг уу?		Үйл ажиллагааны төлөвлөгөө болон үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн тайлан		
2		Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-өөс баталсан стратеги төлөвлөгөө, бодлогын баримт бичиг, дүрэм журмуудын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх?		Гүйцэтгэх удирдлагын үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн тайлан, Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ		ТУЗ-өөс гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ, дүгнэлт?
3		Гүйцэтгэх удирдлагын ажлын туршлага болон мэргэжлийн ур чадвар нь тавигдах шаардлагад нийцсэн эсэх?		Гүйцэтгэх захирлын CV, ТУЗ-өөс баталсан тавигдах шаардлага		
4		ТУЗ-д компанийн үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж буй эсэх талаар, учирч болзошгүй эрсдэл, нөхцөл байдлын талаар тухай бүр тайлагнаж, өгсөн үүргийн хэрэгжилтийг хангаж ажилладаг эсэх?		ТУЗ-д танилцуулсан мэдээ, тайлан, ТУЗ-өөс өгсөн чиглэл, түүний хэрэгжилт		
5		Компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлсэн эсэх?		Үйл ажиллагааны төлөвлөгөө Ажлын тайлан		
<b>НИЙТ ДҮН</b>						

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ**

№	Гарчиг	Асуулт	Компанийн засаглалын кодексыг, Компанийн тухай хууль	Баталгаажуулах баримт бичиг	Үнэлгээ /тийм 2, хагас 1, үгүй 0/	Тайлбар /бүрэн ба хагас биелсэн тохиолдолд/
1	Үйл ажиллагаа	Компанийн санхүү, үйл ажиллагаа, бүтэцэд гарсан томоохон өөрчлөлтийн талаарх мэдээллийг олон нийтэд тухай бүр хүргэсэн эсэх?	"Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам"-ын 3.2	Компанийн цахим хуудас Бусад мэдээллийн эх сурвалж		
2		Компанийн жилийн үйл ажиллагааны тайланг олон нийтэд хүргэсэн эсэх?	"Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам"-ын 2.2	Үйл ажиллагааны тайлан		
3		Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги, гүйцэтгэлийг үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 2.3.1.1	Үйл ажиллагааны тайлан		
4		Компанийн зах зээлд эзлэх байр суурь, нөлөөг үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 2.3.1.2	Үйл ажиллагааны тайлан		
5		Компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон өөрчлөлтийн талаар үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 2.3.1.3	Үйл ажиллагааны тайлан		
6		Компанийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц зах зээлд гарсан өөрчлөлт, учирч болзошгүй томоохон эрсдэлийн талаар үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 2.3.1.4	Үйл ажиллагааны тайлан		
7		Бизнесийн тогтвортой байдлын талаар үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 2.3.1.5	Үйл ажиллагааны тайлан		
8		Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлын талаар үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 2.3.1.6	Үйл ажиллагааны тайлан		

ТӨСӨЛ 2022.02.21

9	Удирдлага	Эрх бүхий албан тушаалтнуудын талаар үйл ажиллагааны тайланд мэдээлсэн эсэх?	Журмын 2.3.2.2	Үйл ажиллагааны тайлан		
10		Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороодын тайланг үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 2.3.2.4, 2.3.2.5	Үйл ажиллагааны тайлан		
11		Дотоод аудитын тайланг компанийн үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	КЗК-ын 8 дугаар бүлэг	Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан		
12		Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн биелэлтийн талаар үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 2.3.2.6	Үйл ажиллагааны тайлан		
13	Санхүүгийн байдал	Компанийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээг үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 2.3.3.1			
14		Аудитын байгууллагаар батлагдсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүний тайлбар, тодруулга, дүгнэлтийг үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 2.3.3.2			
15		Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 2.3.3.3, КТХ-ийн 89.5	Үйл ажиллагааны тайлан		
16		Зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа, баталгаа гаргасан талаар үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 2.3.3.5	Үйл ажиллагааны тайлан		
7	Хувьцаа эзэмшигч	Нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийг үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 3.2.3.3	Үйл ажиллагааны тайлан		
18		Эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 2.3.4.2	Үйл ажиллагааны тайлан		
19		Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийг үйл ажиллагааны тайланд тусгасан эсэх?	Журмын 2.3.4.3	Үйл ажиллагааны тайлан		
20	Ногдол ашиг	Ногдол ашиг хуваарилсан тохиолдолд ногдол ашиг хуваарилалтын тайлан, хуваарилаагүй тохиолдолд энэ тухай үндэслэлийг хувьцаа эзэмшигчид танилцах боломжийг олгосон эсэх?	КЗК-ын 2.2.2	Компанийн цахим хуудас Бусад мэдээллийн эх сурвалж		
<b>НИЙТ ДҮН</b>						

ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО						
№	Гарчиг	Асуулт	Компанийн засаглалын кодекс, Компанийн тухай хууль	Баталгаажуулах баримт бичиг	Үнэлгээ /тийм 2, хагас 1, үгүй 0/	Тайлбар /бүрэн ба хагас биелсэн тохиолдолд/
1	Дотоод хяналт	Гүйцэтгэх захирал дотоод хяналтын бодлогын баримт бичиг, дүрэм журмыг баталсан эсэх?	КЗК-ын 8.1.1	Дотоод хяналтын бодлогын баримт бичиг		
2		Гүйцэтгэх захирал дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлсэн эсэх?	КЗК-ын 8 дугаар бүлэг	Төлөвлөгөө Гүйцэтгэлийн тайлан		
3		Дотоод хяналтын төлөвлөгөөний хэрэгжилтийг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнасан эсэх?	КЗК-ын 8 дугаар бүлэг	ТУЗ-ийн хурлын тэмдэглэл		
4		Дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулсан эсэх?	КЗК-ын 8 дугаар бүлэг	Сургалтын тайлан		

ТӨСӨЛ 2022.02.21

5	Эрсдэлийн удирдлага	Төлөөлөн удирдах зөвлөлөөс эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг баталсан эсэх?	КЗК-ын 9.1	Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг		
6		Гүйцэтгэх удирдлагын зүгээс эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсэн эсэх?	КЗК-ын 9.3	Төлөвлөгөө Гүйцэтгэлийн тайлан		
7		Гүйцэтгэх удирдлага нь эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөний гүйцэтгэлийг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнасан эсэх?	КЗК-ын 9.3	ТУЗ-ийн хурлын тэмдэглэл		
8		Дотоод аудитын нэгжээс эрсдэлийн удирдлагын бодлого, төлөвлөгөө, түүний гүйцэтгэлд үнэлгээ хийсэн эсэх?	КЗК-ын 8.1.4	Дотоод аудитын эрсдэлийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж		
9	Дотоод аудит	Төлөөлөн удирдах зөвлөлөөс дотоод аудитын бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны дүрэм, журам, гарын авлага зэргийг баталсан эсэх?	КЗК-ын 8 дугаар бүлэг	Дотоод аудитын бодлогын баримт бичиг, дүрэм, журам		
10		Төлөөлөн удирдах зөвлөл нь гүйцэтгэх удирдлагаас хараат бус дотоод аудитын нэгж/ажилтныг томилж, цалин урамшуулал, үйл ажиллагааны төсвийг баталсан эсэх?	КЗК-ын 8.1.4	ТУЗ-ийн шийдвэр		
11		Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг бүрэн хангасан эсэх?	КЗК-ын 8 дугаар бүлэг	Эрсдэлийн үнэлгээ, Дотоод аудитын төлөвлөгөө		
12		Дотоод аудитын ажлын тайланг гүйцэтгэх захиралтай зөвшилцөж, Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнасан эсэх?	КЗК-ын 8 дугаар бүлэг	Дотоод аудитын тайлангийн баталгаажилт ТУЗ-ийн хурлын тэмдэглэл		
13		Дотоод аудитын тайланд туссан зөвлөмжийн хэрэгжилтэд эргэн хяналт тавьдаг эсэх?	КЗК-ын 8 дугаар бүлэг	Дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан		
<b>НИЙТ ДҮН</b>						

Нээлттэй асуулга /компанийн засаглалын үнэлгээнд хамаарахгүй/:

1. Компанийн засаглалын зарчмыг сайжруулахад тулгарч буй хүндрэл, бэрхшээлүүдийн талаар дэлгэрэнгүй бичнэ үү.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга компанийн засаглалын ахисан шатны сургалтад хамрагдах шаардлагатай эсэх?
3. Бусад санал: